



БИЕЭ ҮНЭЛЭЛТ БОЛОН БЭЛГИЙН МӨЛЖЛӨГТ ӨРТӨХ ЭРСДЭЛ

СУДАЛГААНЫ
ТАЙЛАН 2019



БИЕЭ ҮНЭЛЭЛТ БОЛОН БЭЛГИЙН МӨЛЖЛӨГТ ӨРТӨХ ЭРСДЭЛ

СУДАЛГААНЫ
ТАЙЛАН

2019

Уг судалгааг БНСУ-ын Жендэрийн тэгш эрх, гэр бүлийн яам (MOGEF), Солонгосын эмэгтэйчүүдийн хүний эрхийн хүрээлэн (WHRIC)-гийн дэмжлэгтэйгээр Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Хүйсийн тэгш эрхийн төвийн судалгааны баг хийж гүйцэтгэлээ.

ТАЛАРХАЛ

БНСУ-ын Жендэрийн тэгш эрх, гэр бүлийн яам (MOGEF), Эмэгтэйчүүдийн хүний эрхийн хүрээлэн (WHRIK)-гийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн “Биеэ үнэлэлт болон бэлгийн мөлжлөгт өртөх эрсдэл” судалгааг амжилттай зохион байгууллаа. Судалгааны багийнхан болон судалгаа зохион байгуулагдах хугацаанд дэмжлэг, туслалцаа үзүүлсэн ХНХЯ-ны Хүүхэд, Залуучууд, Ахмад настан, Гэр бүлийн хөгжлийн хэлтэс болон бүх оролцогч байгууллага, хувь хүмүүст талархлаа илэрхийлье. Эдгээр хүмүүсийн оролцоо, дэмжлэггүйгээр бид энэхүү судалгааг амжилттай явуулах, тайланг гаргах боломжгүй юм.

Ялангуяа ХНХЯ-ны Хүүхэд, Залуучууд, Ахмад настан, Гэр бүлийн хөгжлийн хэлтсийн дарга Н.Баярмаа, мэргэжилтэн Р.Нарантуяа нарт болон Дорноговь аймгийн Замын-Үүд сум, Өмнөговь, Дархан-Уул, Дорнод аймаг, УБ хотын 6 дүүргийн шүүх, прокурор, цагдаа, ГБХЗХГ-ын удирдлага болон мэргэжилтнүүд, мөн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагын хамт олон, ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагад цаг заваа гарган оролцож санал бодлоо чөлөөтэй илэрхийлсэн хүмүүст баярласнаа илэрхийлье. Мөн бидэнд итгэж мэдээллээ хуваалцсан судалгаанд оролцсон иргэдэд талархсанаа илэрхийлж байна.

Энэхүү судалгаа нь биеэ үнэлэлт, бэлгийн мөлжлөгийн асуудлаар ажилладаг төрийн ба төрийн бус байгууллагуудад урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хохирогч хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа хэрэгжүүлэх, энэ чиглэлээр хамтран ажиллахад хувь нэмрээ оруулна гэдэгт итгэж байна.

Судалгааны багийн хамт олон

АГУУЛГА

Хүснэгтийн жагсаалт
Зургийн жагсаалт
Товчилсон үгийн жагсаалт

БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 1.1 Судалгааны зорилго
- 1.2 Судалгааны хамрах хүрээ
- 1.3 Судалгааны түүвэрлэлт
- 1.4 Судалгааны асуулгын хуудас
- 1.5 Судалгааны мэдээлэл цуглуулагчийн сургалт
- 1.6 Судалгааны мэдээлэл цуглуулалт, боловсруулалт
- 1.7 Чанарын судалгаа
- 1.8 Тайлангийн бүтэц, агуулга
- 1.9 Судалгааны товч дүн

БҮЛЭГ 2. СУДАЛГААНД ХАМРАГДАГЧДЫН ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

БҮЛЭГ 3. БИЕЭ ҮНЭЛЭЛТ

- 3.1 Биеэ үнэлэлтийн талаарх үзэл бодол
- 3.2 Биеэ үнэлэгчдийг худалдан авагч нарт ял шийтгэл оногдуулах талаарх үзэл бодол

БҮЛЭГ 4. БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ

БҮЛЭГ 5. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БОЛОН ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХ ҮЗЭЛ БОДОЛ

БҮЛЭГ 6. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

- Хавсралт 1. Үр дүнгийн хүснэгтүүд
Хавсралт 2. Асуулгын хуудас
Хавсралт 3. Бүлгийн ярилцлагын хуудас
Хавсралт 4. Ганцаарчилсан ярилцлагын хуудас

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1.1 Судалгааны бүлэг тус бүрээс сонгогдсон түүврийн анхан шатны нэгж, хамрагдах хүний тоо
- Хүснэгт 2.1 Судалгаанд хамрагдсан хүний тоо, насны бүлэг, байршлаар
- Хүснэгт 2.2 Судалгаанд хамрагдсан хүний тоо, боловсролын түвшин, хүйсээр, дүнд эзлэх хувиар
- Хүснэгт 2.3 Судалгаанд хамрагдсан хүний тоо, хүйс, гэрлэлтийн байдал, хүүхэдтэй эсэхээр
- Хүснэгт 3.1 Биеэ үнэлэлтийн талаарх судалгаанд хамрагдагчдын үзэл бодол, дүнд эзлэх хувиар
- Хүснэгт 3.2 Биеэ үнэлэгчдийг худалдан авагч нарт хуулийн хариуцлага хүлээлгэх эсэх талаарх судалгаанд хамрагдагчдын үзэл бодол, дүнд эзлэх хувиар
- Хүснэгт 4.1 Бэлгийн мөлжлөгийн талаарх судалгаанд хамрагдагчдын үзэл бодол, дүнд эзлэх хувиар

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- Зураг 2.1 Судалгаанд хамрагдагчдын бүтэц, байршлаар, хүний тоогоор
- Зураг 2.2 Судалгаанд хамрагдагчдын насны бүтэц, хүний тоогоор
- Зураг 2.3 Судалгаанд хамрагдагчдын ажил эрхлэлтийн байдлын бүтэц, хувиар
- Зураг 2.4 Судалгаанд хамрагдагчдын орлогын эх үүсвэрийн бүтэц, хувиар
- Зураг 2.5 Одоогийн оршин сууж буй газартаа хэр удаан амьдарч байгаа, жил, хувиар
- Зураг 2.6 Танайх өмнө нь хаана оршин сууж байсан бэ?, суурьшлаар, хувиар
- Зураг 3.1 Судалгаанд хамрагдагчдын Монголд биеэ үнэлэлт хэр их байдаг талаарх үзэл бодол, хувиар
- Зураг 3.2 Судалгаанд хамрагдагчдын Монголд биеэ үнэлэлт хэр их байдаг талаарх үзэл бодол, байршлаар, хувиар
- Зураг 3.3 Судалгаанд хамрагдагчдын Монголд биеэ үнэлэлт хэр их байдаг талаарх үзэл бодол, ажил эрхлэлтийн байдлаар, хувиар
- Зураг 3.4 Судалгаанд хамрагдагчдын Монголд биеэ үнэлэлтийг хууль ёсны болгох талаарх үзэл бодол, хүйсээр, хүний тоогоор
- Зураг 3.5 Насанд хүрэгчдэд бэлгийн харьцааг мөнгөөр худалдаж авах зөвшөөрөл олгох талаарх судалгаанд хамрагдагчдын үзэл бодол, хүйсээр, хүний тоогоор
- Зураг 3.6 Биеэ үнэлэлтийг хуулиар зөвшөөрвөл эрэлт нэмэгдэнэ гэсэн асуултын талаарх үзэл бодол, хүйсээр, хүний тоогоор
- Зураг 3.7 Биеэ үнэлэлт аль ч нийгэмд байх л ёстой гэсэн асуултын талаарх үзэл бодол, хүйсээр, хүний тоогоор
- Зураг 3.8 Биеэ үнэлэлтийг хуулиар зөвшөөрснөөр эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгт ашиглах явдлаас сэргийлж чадна гэсэн асуултын талаарх судалгаанд хамрагдагчдын үзэл бодол, хүйсээр, хүний тоогоор
- Зураг 3.9 Биеэ үнэлэлт саун, массаж, шөнийн цэнгээний газрууд гэлтгүй хаа сайгүй явагдаж байна гэсэн асуултын талаарх судалгаанд хамрагдагчдын үзэл бодол, хүйс, хувиар
- Зураг 3.10 Биеэ үнэлэлтийг хүлээн зөвшөөрвөл худалдан авагчдын тоо нэмэгдэнэ гэсэн асуултын талаарх судалгаанд хамрагдагчдын үзэл бодол, хүйсээр, хүний тоогоор
- Зураг 3.11 Биеэ үнэлэх болсон шалтгааны бүтэц, судалгаанд хамрагдагчдын бодлоор, хувиар

- Зураг 3.12 Биеэ үнэлэлтийн талаарх өнөөгийн хууль тогтоомжид заасан хариуцлагууд оновчтой гэж бодож байна уу? гэсэн асуултад судалгаанд хамрагдагчдын өгсөн хариулт, хувиар
- Зураг 3.13 Биеэ үнэлэгчдийг худалдаж авсны улмаас хуулийн хариуцлага хүлээж буй этгээдийн нэрийг олон нийтэд зарлах хэрэгтэй гэсэн асуултад судалгаанд хамрагдагчдын өгсөн хариулт, хувиар
- Зураг 3.14 Охид, эмэгтэйчүүдтэй бэлгийн харилцаанд орохын тулд худалдаж авсан хүмүүст ял, шийтгэл оноох ёстой гэсэн олон нийтийн чиг хандлага, хувиар
- Зураг 3.15 Охид, эмэгтэйчүүдтэй бэлгийн харилцаанд орохын тулд худалдан авсан хүмүүс торгууль төлөх ёстой гэсэн асуултад судалгаанд хамрагдагчдын өгсөн хариулт, хувиар
- Зураг 4.1 Бэлгийн мөлжлөгийн талаар сонсож байсан эсэх, байршлаар, хувиар
- Зураг 4.2 Хүний наймаачид ихэвчлэн эмзэг бүлгийн охид, эмэгтэйчүүдийг худалддаг гэсэн асуултад судалгаанд хамрагдагчдын өгсөн хариулт, хувиар
- Зураг 4.3 Хүний наймаачид ихэвчлэн сул дорой, эмзэг бүлгийн хэн нэгнийг өөрсдийн орлого олох эх үүсвэрээ болгон ашигладаг гэсэн асуултад судалгаанд хамрагдагчдын өгсөн хариулт, хувиар
- Зураг 4.4 Судалгаанд хамрагдагчдын хүсэж буй урьдчилан сэргийлэх мэдээллийн төрлийн бүтэц, хувиар
- Зураг 5.1 Энэ гэмт хэрэгтэй тэмцэх боломжтой гэж хариулсан хүний саналын бүтэц, байршлаар, хувиар
- Зураг 5.2 Гэмт хэрэгтэй тэмцэхэд судалгаанд хамрагдагчдын оруулах хувь нэмэр, төрлөөр, хувиар
- Зураг 5.3 Гэмт хэргийг таслан зогсоохын тулд явуулах үйл ажиллагааны төрөл, судалгаанд хамрагдагчдын үзэл бодлоор

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ТББ	Төрийн бус байгууллага
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
НЦГ	Нийслэлийн цагдаагийн газар
ОНХА	Олон нийттэй харилцах алба
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ОХУ	Оросын Холбооны Улс
ЖТЭГБЯ	Жендэрийн тэгш эрх, гэр бүлийн яам
ЭХЭХ	Эмэгтэйчүүдийн хүний эрхийн хүрээлэн
ХНХЯ	Хөдөлмөр, нийгэм хамгааллын яам
ХХГХ	Хүн худалдаалах гэмт хэрэг
ХТЭТ	Хүйсийн тэгш эрхийн төв ТББ
МСҮТ	Мэргэжил, сургалтын үндэсний төв
ГБХЗГ	Гэр бүл, Хүүхэд Залуучуудын Хөгжлийн Газар
ТАШН	Түүврийн анхан шатны нэгж

БҮЛЭГ 1

Судалгааны зорилго,
арга зүй, зохион байгуулалт

БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Оршил

Монгол Улс нь зүүн Азийн зүүн хойд хэсэгт нийт 1564.1 мянган хавтгай дөрвөлжин километр газар нутгийг эзлэн оршдог бөгөөд хойд хэсгээрээ Оросын Холбооны Улс, өмнөд хэсгээрээ Бүгд Найрамдах Хятад Ард Улстай хиллэдэг далайд гарцгүй орон. Монгол Улсын хүн ам 3.2 сая¹, хөдөө аж ахуй, нүүдлийн мал аж ахуйн уламжлалтай, зэс нүүрс экспортлодог, хөгжиж буй орон.

Монгол Улс нь 1961 онд НҮБ-ын гишүүн болж, дэлхийн 184 улстай дипломат харилцаа тогтоосон бүрэн эрхт улс. Монгол Улс нь олон улсын хүний эрхийн суурь зарчим, стандартуудыг хангахыг бүрэн дэмждэг бөгөөд эмэгтэйчүүдийн эрх, жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилт бүхий олон улсын гэрээ, хэлцлүүдэд гарын үсэг зурж нэгдэн орсон улс юм.

Монгол Улс хүн худалдаалах гэмт хэрэг(ХХГХ)-ийн эсрэг олон улсын гэрээнүүдэд нэгдэн орсноор уг гэмт хэрэгтэй тууштай тэмцэх үүргийг Дэлхийн хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн бөгөөд хүний наймаанд өртөх өндөр эрсдэлтэй орны тоонд багтаж буйн хувьд ийм төрлийн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлыг төрийн хууль тогтоох бодлогын хүрээнд зохицуулж, тодорхой алхамуудыг хийж эхлээд цөөнгүй жилийг үдэж байгаа ч ХХГХ-тэй тэмцэх, таслан зогсоох нь Монгол Улсад тулгамдсан асуудлын нэг хэвээр байна. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль (2011), Эрүүгийн хууль (2015), Зөрчлийн хууль (2015), Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль (2014) болон эдгээрийг дагаж гарсан журмуудын бодит хэрэгжилт, уялдаа холбоог хангах, биеэ үнэлэлт, бэлгийн мөлжлөгт өртсөн эмэгтэйчүүд нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, золиос болох эрсдэл их байдагтай холбоотойгоор бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахад шаардлагатай суурь тоо мэдээлэл зайлшгүй шаардлагатай болоод байна. Мөн хохирогчдын эрхийг хамгаалах, нөхөн сэргээхэд зориулсан олон хууль дүрэм, журмууд батлагдсан ч хэрэгжилтэд шаардагдах төсөв хөрөнгийг шийдвэрлээгүй, хохирогчдод зориулсан цогц системтэй үйлчилгээ хангалттай бус байна.

Иймд дээрх нөхцөл байдлыг үндэслэн ХНХЯ, Хүйсийн Тэгш Эрх Төв ТББ-ын хамтарсан “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчдод туслалцаа үзүүлэх” 5 жилийн төслийг Монгол Улсад хэрэгжүүлэх гэж байгаа нь биеэ үнэлэлтийг бууруулах, бэлгийн мөлжлөгийн хохирогчдод цогц туслалцаа үзүүлж нөхөн сэргээхэд чухал үр нөлөөтэй гэж үзэж байна.

¹ <https://www.nso.mn/>

1.1 Судалгааны зорилго

Улаанбаатар хот болон эрсдэлтэй, хилийн бүс нутгууд Дорноговь аймгийн Замын-Үүд сум, Өмнөговь, Дорнод, Дархан-Уул, Орхон аймгуудад ажиллаж амьдарч байгаа биеэ үнэлэлт, бэлгийн мөлжлөгийн хохирогчтой тодорхой хэмжээнд хүрч ажилладаг хуулийн байгууллага болон бусад төрийн, төрийн бус байгууллагын ажилтнууд, 16-аас дээш насны орон нутгийн иргэдээс суурь судалгаа авч, тодорхой хүмүүстэй ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага хийж биеэ үнэлэлт, бэлгийн мөлжлөгт өртөх эрсдэл, эмзэг байдлыг тодорхойлох юм.

Судалгааны зорилтууд:

- Биеэ үнэлэлт болон бэлгийн мөлжлөгийн өнөөгийн байдал;
- Биеэ үнэлэлт, бэлгийн мөлжлөгийн талаарх хүмүүсийн хандлага, хүнд худалдаалах гэмт хэргийн үндсэн шалтгааны талаарх санал бодлыг тодорхойлох;
- Бэлгийн мөлжлөгт өртөх эрсдэлийг тогтоох;
- Ял шийтгэлийн оновчтой бодлого;
- Биеэ үнэлэлт болон бэлгийн мөлжлөг үйлдэгдэж байгаа үндсэн шалтгаан, хүчин зүйлийг тогтоох;
- Зорилтот бүс нутгуудад хохирогч хамгааллын үйлчилгээ, шууд туслалцаа авч болох боломжуудыг тодорхойлох;
- Бүс нутаг тус бүрт биеэ үнэлэлт, бэлгийн мөлжлөгийн урьдчилан сэргийлэх, тэмцэх үр дүнтэй арга аргачлалыг хэрэгжүүлэх боломжийг тогтоох явдал юм.

1.2 Судалгааны хамрах хүрээ:

Судалгааг БНСУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжиж буй “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчдод туслалцаа үзүүлэх” төслийн хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хүйсийн Тэгш Эрх Төв ТББ-ын хамтарсан баг, БНСУ-ын Гэр бүл, жендэрийн тэгш эрхийн яам (MOGEF), Эмэгтэйчүүдийн хүний эрхийн хүрээлэн (WHRIC)-ийн аргазүйгээр Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэг, Дорноговь аймгийн Замын-Үүд сум, Өмнөговь аймгийн Даланзадгад сум, Гашуун сухайт боомт, Дорнод, Дархан-Уул, Орхон аймгуудад хийсэн.

Судалгааны зорилтот хүн ам нь орон нутгийн иргэдээс гадна хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтнууд болох цагдаа, шүүх, прокурорын төлөөлөл, биеэ үнэлэлт, бэлгийн мөлжлөгийн хохирогчтой тодорхой хэмжээнд хүрч ажилладаг төрийн, төрийн бус байгууллагын ажилтнууд болон орон нутгийн иргэд юм.

1.3 Судалгааны түүвэрлэлт

Судалгааны түүвэрлэлтийг “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчдод туслалцаа үзүүлэх” төсөл хэрэгжих Улаанбаатар хот болон эрсдэл өндөртэй хилийн бус нутгууд болох Замын-Үүд, Өмнөговь, Дорнод, Дархан-Уул, Орхон аймгуудад хийсэн.

Түүврийн бүлэг:

- Бүлэг 1: Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтнууд (цагдаа, шүүгч, прокурор)
- Бүлэг 2: Орон нутгийн төрийн захиргааны нийгмийн бодлогын асуудал хариуцсан дарга, нийгмийн ажилтнууд, ГБХЗХГ-ын мэргэжилтнүүд
- Бүлэг 3: Төрийн бус байгууллагын ажилтнууд
- Бүлэг 4: Орон нутгийн иргэдийн төлөөлөл (16-аас дээш насны)

Хүснэгт 1.1

Судалгааны бүлэг тус бүрээс сонгогдсон ТАШН, судалгаанд хамрагдах хүний тоо

Аймаг, дүүрэг	Судалгаанд хамрагдах бүлэг, хүний тоо							Бүгд
	Цагдаагийн ажилтан	Шүүгч	Прокурор	ГБХЗХГ	Нийгмийн ажилтан	ТББ-ын ажилтан	Орон нутгийн иргэд	
1 Сүхбаатар	15	5	5	5	5	5	20	60
2 Баянгол	15	5	5	5	5	5	20	60
3 Хан-Уул	15	5	5	5	5	5	20	60
4 Чингэлтэй	15	5	5	5	5	5	20	60
5 Баянзүрх	15	5	5	5	5	5	20	60
6 Сонгино-Хайрхан	15	5	5	5	5	5	20	60
7 Дорноговь аймгийн Замын-Үүд сум	15	5	5	5	5	5	30	70
8 Өмнөговь аймаг, Гашуун- Сухайт боомт	15	5	5	5	5	5	30	70
9 Дархан-Уул	15	5	5	5	5	5	30	70
10 Орхон	15	5	5	5	5	5	30	70
11 Дорнод	15	5	5	5	5	5	30	70
ДҮН	165	55	55	55	55	55	270	710

1.4 Судалгааны асуулгын хуудас

Судалгааны зорилго, зорилтууд, хамрах хүрээг харгалзан, төслийн хамтран хэрэгжүүлэгч гадаад болон дотоодын байгууллагуудын өгсөн зөвлөмж, аргачлал, арга зүй болон энэ төрлийн судалгаа хийсэн гадаад, дотоод байгууллагуудын туршлагыг судалсны үндсэн дээр судалгааны асуулгыг боловсруулав. Судалгааны асуулга нь тухайн орон нутаг дахь биеэ үнэлэлт болон бэлгийн мөлжлөгийн талаарх ойлголт, мэдлэг, энэ гэмт хэргийн нөхцөл байдлын шалтгаан, үр дагавар, цаашдын бодол, хандлагыг судлах 7 бүлэг бүхий 39 асуулгаас бүрдэнэ. Үүнд:

А. Лавлагааны хэсэг

Бүлэг I. Ерөнхий мэдээлэл

Бүлэг II. Шилжилт хөдөлгөөн

Бүлэг III. Биеэ үнэлэлтийн талаарх ойлголт, мэдлэг

Бүлэг IV. Бэлгийн мөлжлөгийн талаарх ойлголт, мэдлэг

Бүлэг V. Ял шийтгэл оногдуулах талаар

Бүлэг VI. Урьдчилан сэргийлэх болон тэмцэх, таслан зогсоох талаар

Бүлэг VII. Цаашид авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаарх санал бодол

1.5 Мэдээлэл цуглуулагчийн сургалт

Судалгааны ажлыг чанартай сайн гүйцэтгэх, шаардлага хангасан мэдээлэл цуглуулах үүднээс судалгааны ахлагч болон мэдээлэл цуглуулагч нарт зориулсан сургалтыг зохион байгуулсан. Сургалтаар судалгааны үндсэн зорилго, ач холбогдол, арга, арга зүй болон хэрэглэгдэж буй ойлголт, тодорхойлолтуудыг тайлбарлан, асуулгын хуудсыг нөхөн, ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлагын талаар дэлгэрэнгүй зааварчилгаа тайлбар өгч, гарын авлагыг бэлтгэсэн. Мөн судалгаа авахад анхаарах ёс зүй, аюулгүй байдлын асуудлаар мэдээлэл өгсөн болно.

Мэдээлэл цуглуулагчийн гүйцэтгэх ажил үүрэг, хариуцлага

- Судалгааны зорилго, зорилт, арга зүй, үйл ажиллагааны төлөвлөлттэй сайтар танилцаж, судалгааг орон нутагт явуулах ач холбогдлын талаар үзэл баримтлалтай болох;
- Мэдээлэл цуглуулах явцад гарах аливаа хүндрэл бэрхшээлийг мэдээлэл цуглуулах багийн ахлагчид мэдэгдэх;
- Судалгааны багийн удирдлага, зохион байгуулалтын хүрээнд баримтлах бүхий л хэм хэмжээг баримтлах;
- Цуглуулсан мэдээлэлтэй асуулгын маягтыг багийн ахлагчид хүлээлгэн өгөх, хянуулах;

- Өдөр бүрийн мэдээлэл цуглуулалтын явцын талаар багийн ахлагчид мэдээлэх;
- Мэдээллийн чанарт нөлөөлөхүйц урьдчилан тооцоолоогүй аливаа асуудал үүсвэл дур мэдэн шийдвэрлэхгүйгээр багийн ахлагчид мэдэгдэх;
- Мэдээлэл цуглуулагчид нь сонгогдсон зорилтот бүлгийн төлөөлөлтэй уулзан асуулгын маягыг үнэн зөв бөглөх;
- Мэдээлэл оруулах багийн ахлагчийн удирдлага дор нүүр тулсан ярилцлагын арга техникээр мэдээлэл цуглуулах;
- Цуглуулсан мэдээллийг аюулгүй хадгалж хамгаалан мэдээлэл цуглуулах багийн ахлагчид хүлээлгэн өгөх;
- Мэдээллийг хэрхэн үнэн зөв, бүрэн гүйцэд цуглуулахаас мэдээллийн чанар хамаарч энэ нь мэдээлэл цуглуулагч нарын хариуцлагатай шууд холбоотой.

Мэдээлэл цуглуулагч нарын баримтлах ёс зүй

- Мэдээлэл өгсөн хүмүүст судалгааны зорилгод үл хамаарах ямар нэг амлалт өгч, аль нэг хүлээлт, горьдлого төрүүлэхгүй байх;
- Мэдээлэл цуглуулагч нар болон багийн бусад гишүүд судалгааны мэдээллийг судалгааны зорилгод хамаарахгүй байдлаар бусдад дамжуулахгүй байх;
- Судалгааны холбогдох мэдээллийг бүрэн дүүрэн цуглуулж, түүний иж бүрэн байдлыг хариуцах;
- Мэдээлэл цуглуулах явцдаа судалгаанд оролцож мэдээлэл өгч буй хүмүүсийн нэр төр, үнэ цэнэ, эрх чөлөөг дээдлэн ажиллах;
- Хүмүүсийг байгаа байдлаар хүлээн авч, үл ялгаварлах үзлээр мэдээлэл авч ажиллах;
- Ярилцлага хийх цагийн менежментийг тооцож ажиллах;
- Аймаг, сум, багийн түвшинд ажиллаж буй төрийн албан хаагчидтай хамтран ажиллах учраас багаар ажиллах чадвартай байх;
- Ёс зүйн бүхий л хэм хэмжээг баримтлан ажиллах.

1.6 Судалгааны мэдээлэл цуглуулалт, боловсруулалт

Судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг ХНХЯ, Хүйсийн Тэгш Эрх Төв ТББ хамтран удирдан зохион байгуулсан. Судалгааны ахлагчийн шууд удирдлага дор багууд сонгогдсон орон нутаг, дүүргүүдээс өгөгдсөн зааварчилгааны дагуу судалгаанд хамрагдагчидтай тусгайлан уулзаж мэдээлэл цуглуулсан. Мэдээлэл цуглуулах ажлыг 2019 оны 08 сарны 20-31-ны хооронд хийж гүйцэтгэлээ. Судалгааны

асуудлыг шалган хүлээж авч, компьютерт шивж оруулан, бэлэн болсон мэдээллийг тусгай программыг (SPSS 22.0 болон Ехсел) ашиглан цуглуулсан мэдээллийг өгөгдлийн санд шивж оруулах, бүрдэлтийг хянах, засварлах, боловсруулах нэгдсэн үр дүнг гарган тайлан бичих ажлуудыг Хүйсийн Тэгш Эрх Төв ТББ хийж гүйцэтгэсэн.

1.7 Чанарын судалгаа

Чанарын судалгааны хүрээнд тоон судалгаанаас гарах боломжгүй эсвэл баталгаажуулах шаардлагатай нэмэлт мэдээллийг цуглуулахын тулд 94 мэргэжилтэн, орон нутгийн иргэдтэй 16 фокус бүлгийн ярилцлага хийж, гүнзгийрүүлсэн ярилцлагыг 22 удирдах ажилтан, мэргэжилтнүүдийн дунд зохион байгууллаа.

Чанарын судалгааг биеэ үнэлэлт, бэлгийн мөлжлөгийн хохирогчтой ямар нэг байдлаар ажилладаг, тэдэнд үйлчилгээ, тусламж үзүүлдэг төрийн болон төрийн бус байгууллагын удирдах ажилтан, мэргэжилтэн болон иргэдийн дунд ярилцлага хийсэн. Үйл ажиллагааг зохион байгуулахдаа ХНХЯ, холбогдох аймаг дүүргийн Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын Хөгжлийн газартай хамтран ажилласан. Эдгээр мэдээлэл нь тоон судалгааны үр дүнг дэмжих, асуудлыг бүрэн үнэлж, танилцуулахад ашиглахаас гадна дараагийн судалгааны асуулга, арга зүйг боловсронгуй болгон сайжруулахад чухал ач холбогдолтой.

1.8 Тайлангийн бүтэц, агуулга

Биеэ үнэлэлт болон бэлгийн мөлжлөгт өртөх эрсдэл судалгааны үр дүнгийн тайлан нь дараах 6 бүлгээс бүрдэнэ. Үүнд:

- Бүлэг 1. Судалгааны зорилго, арга зүй, зохион байгуулалт
- Бүлэг 2. Судалгаанд хамрагдагчдын хүн ам зүйн үзүүлэлтүүд
- Бүлэг 3. Биеэ үнэлэлт
- Бүлэг 4. Бэлгийн мөлжлөг
- Бүлэг 5. Урьдчилан сэргийлэх ба цаашид авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаарх үзэл бодол
- Бүлэг 6. Дүгнэлт ба зөвлөмж

Тайлангийн 1-р бүлэгт судалгааны зорилго, ач холбогдол, арга зүй, зохион байгуулалт, тайлангийн бүтэц, судалгааны товч үр дүнгийн талаар, Бүлэг 2-т судалгаанд хамрагдагчдын хүн ам зүйн үзүүлэлтүүд, Бүлэг 3-т биеэ үнэлэлт, биеэ үнэлэх болсон шалтгаан болон биеэ үнэлэгч нарыг худалдан авч буй хүмүүст оногдуулах ял, шийтгэлийн талаарх судалгаанд хамрагдагчдын мэдлэг, ойлголт, үзэл бодол, хандлага, Бүлэг 4-т бэлгийн мөлжлөгийн талаарх мэдлэг, ойлголт, бэлгийн мөлжлөгт өртөгчдийн талаарх мэдээлэл, урьдчилан сэргийлэх

мэдээллийг хэрхэн авч байсан цаашид ямар хэлбэрээр авах хүсэлтэй байгаа талаар, Бүлэг 5-д энэ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон цаашид тэмцэх, таслан зогсоох талаарх санал бодол, Бүлэг 6-д судалгааны үр дүнгээр гарч буй дүгнэлт, зөвлөмжийг багтаасан болно.

1.9 Судалгааны товч үр дүн

Биеэ үнэлэлт, бэлгийн мөлжлөгийн талаарх олон нийтийн үзэл бодол, мэдлэг, хандлагыг тодорхойлох зорилгоор хийгдсэн энэхүү судалгаанд биеэ үнэлэлт, бэлгийн мөлжлөгийн хохирогчтой тодорхой хэмжээнд хүрч ажилладаг хуулийн байгууллагын ажилтнууд болох цагдаа, шүүх, прокурорын төлөөлөл болон бусад төрийн, төрийн бус байгууллагын ажилтнууд, орон нутгийн иргэдийн төлөөлөл болох 710 хүн хамрагдсан. Судалгаанд хамрагдагчдын биеэ үнэлэлт, бэлгийн мөлжлөгийн талаарх ойлголт, мэдлэгийг олон улсын жишигт нийцүүлэн, олон улсад хийгдсэн судалгааны үр дүнтэй харьцуулагдахуйц, энэ чиглэлээр хийгдэж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх зорилгоор дараах 5 хэмжээсээр хэмжиж гаргасан болно. Үүнд:

- 1) Санал огт нийлэхгүй байна
- 2) Санал нийлэхгүй байна
- 3) Мэдэхгүй
- 4) Санал нийлж байна
- 5) Маш их санал нийлж байна

Энэхүү судалгааны Хавсралт 1-ийн “Үр дүнгийн хүснэгтүүд”-д биеэ үнэлэлт, бэлгийн мөлжлөг, биеэ үнэлэгчдийг худалдан авагч нарт ял шийтгэл оногдуулах талаарх бүх үзүүлэлтүүдийг дээрх 5 хэмжээсээр гаргаж хавсаргав. Харин тайлангийн бүлгүүдэд 5 хэмжээст үзүүлэлтийг дараах хэлбэрээр нэгтгэн үр дүнг танилцуулж байна. Үүнд:

- 1) Санал нийлж байна /Санал нийлж байна + Маш их санал нийлж байна/
- 2) Санал нийлэхгүй байна /Санал нийлэхгүй байна + Санал огт нийлэхгүй байна/
- 3) Мэдэхгүй

Мөн судалгааны хүрээнд энэ чиглэлээр ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагын ажилтнууд, орон нутгийн иргэдийн төлөөлөл оролцсон 16 фокус бүлгийн ярилцлагаас гадна энэ асуудлаар ажилладаг туршлагатай удирдах ажилтан, мэргэжилтнүүдийн дунд гүнзгийрүүлсэн ганцаарчилсан ярилцлагыг зохион байгуулж үр дүнг нэгтгэн танилцуулж байгаа болно.

Биеэ үнэлэлт

- Судалгаанд хамрагдсан нийт 710 хүний 379(53.4 хувь) нь манай орон нутагт биеэ үнэлэлт байдаг гэдэгтэй санал нийлж байна гэсэн бол бүлгийн болон ганцаарчилсан ярилцлаганд оролцогчид өөрсдийнхөө орон нутагт

биеэ үнэлэлт, бэлгийн мөлжлөг ямар нэг хэмжээгээр байдаг гэдгийг хүлээн зөвшөөрч байна.

- Харин судалгаанд хамрагдсан таван хүний хоёр нь манай орон нутагт биеэ үнэлэлт байдаг эсэхийг мэдэхгүй гэж хариулсан байна.
- Судалгаанд хамрагдагчдын 68.0 хувь нь Монгол Улсад биеэ үнэлэлт их байдаг гэж үзэж байна.
- Монголд биеэ үнэлэлтийг хууль ёсны болгохыг судалгаанд хамрагдсан арван хүн тутмын гурав нь л зөвшөөрч байгааг үзэхэд энэ асуудлыг хууль ёсны болгохыг дэмжихгүй байгаа нь харагдаж байна.
- Судалгаанд хамрагдсан арван хүний долоо нь насанд хүрэгчдэд бэлгийн харилцааг мөнгөөр худалдаж авах зөвшөөрөл олгох нь буруу гэж үзэж байна.
- Биеэ үнэлэлтийг хуулиар зөвшөөрвөл эрэлт нэмэгдэнэ гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан арван хүний дөрөв (44.8 хувь) нь санал нийлэхгүй, гурав (26.3 хувь) нь санал нийлж байна, гурав (28.9 хувь) нь мэдэхгүй гэж хариулжээ.
- Биеэ үнэлэлт нь аль ч нийгэмд байх л ёстой асуудал гэдэгтэй судалгаанд хамрагдагчдын дийлэнх нь буюу 79.4 хувь нь санал нийлэхгүй байна.
- Биеэ үнэлэлтийг хуулиар зөвшөөрснөөр эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгт ашиглах явдлаас сэргийлж чадна гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан арван хүний гурав нь л санал нийлж байна гэжээ.
- Судалгаанд хамрагдсан арван хүний долоо нь биеэ үнэлэлт саун, массаж, шөнийн цэнгээний газруудад голдуу явагдаж байна гэж үзэж байна.
- Судалгаанд хамрагдсан арван хүний дөрөв нь биеэ үнэлэлтийг хүлээн зөвшөөрвөл худалдан авагчдын тоо нэмэгдэнэ, харин гурав нь нэмэгдэхгүй гэжээ.
- Биеэ үнэлэх болсон шалтгааныг мөнгө олох, ажилгүйдэл, ядуурал, архидалт, гэр бүлийн таагүй нөхцөл байдал, гэр бүлийн хүчирхийлэл, хүмүүжил, хүндрэлтэй асуудлаа шийдэх, залуучууд амар хялбар аргаар мөнгө олох зорилготой холбоотой гэж үзэж байна.

Бэлгийн мөлжлөг

- Судалгаанд хамрагдсан арван хүний найм нь бэлгийн мөлжлөгийн талаар сонсож байсан, харин хоёр нь сонсож байгаагүй байна.
- Манай орон нутагт бэлгийн мөлжлөг үйлдэгддэг эсэхийг мэдэхгүй гэж нийт судалгаанд хамрагдагчдын 53.4 хувь нь хариулсан байна.
- Биеэ үнэлэлт бол бэлгийн мөлжлөгийн нэг хэлбэр юм гэдэгтэй судалгаанд хамрагдсан хоёр хүний нэг нь санал нийлж байгаа бол бүлгийн ярилцлаганд оролцогчид биеэ үнэлэлт, бэлгийн мөлжлөгийг 2 өөр ойлголт гэж үзсэн байна.
- Судалгаанд хамрагдсан арван хүний долоо нь хүний наймаачид ихэвчлэн эмзэг бүлгийн охид, эмэгтэйчүүдийг худалддаг (74.6 хувь),

сул дорой эмзэг хэн нэгнийг өөрсдийн орлого олох эх үүсвэрээ болгон ашигладаг(76.1 хувь) гэдэгтэй санал нэг байна. Өөрөөр хэлбэл эмзэг бүлгийн охид, эмэгтэйчүүд энэ гэмт хэрэгт хамгийн их өртөж байна гэж үзэж байна.

- Биеэ үнэлж буй охид, эмэгтэйчүүдийн дийлэнх нь өмнө нь бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэргийн хохирогч болсон байдаг гэдэгтэй судалгаанд хамрагдагчдын 45.9 хувь нь санал нийлж байгаа бол 42.6 хувь нь энэ талаар мэдэхгүй гэсэн хариултыг өгсөн байна.
- Судалгаанд хамрагдагдсан 515 (72.5 хувь нь) хүн хэн нэгнийг бэлгийн мөлжлөгийн хохирогч болсныг мэдвэл цагдаад хандана гэсэн байна.
- Биеэ үнэлэлт болон бэлгийн мөлжлөгт өртсөн хохирогчдод туслалцаа үзүүлэх талаар энэ чиглэлээр ажилладаг цагдаа, шүүгч, өмгөөлөгч, нийгмийн ажилтан, гэр бүл, хүүхдийн асуудлаар ажилладаг албан тушаалтнууд нь тодорхой хэмжээний мэдлэг, ойлголттой гэсэн бол олон нийтийн төлөөлөл өөрсдийгөө хангалттай мэдлэг, мэдээлэлгүй гэжээ.

Ял шийтгэл оногдуулах талаар:

- Судалгаанд хамрагдагчдын 70.7 хувь нь биеэ үнэлэгчдийг худалдан авагч нарт хуулийн хариуцлага хүлээлгэх нь зүйтэй гэж үзэж байна.
- Биеэ үнэлэлтийн талаарх өнөөгийн хууль тогтоомжид заасан хариуцлагын арга хэмжээнүүд оновчтой бус хангалтгүй гэж үзэж байна.
- Биеэ үнэлэгчдийг худалдаж авсаны улмаас хуулийн хариуцлага хүлээж буй этгээдийн нэрийг олон нийтэд зарлах, мөн биеэ үнэлэгчдийг худалдан авч буй хүнийг гэмт хэрэгтэн гэж бүртгэж авах ёстой гэсэн асуулганд судалгаанд хамрагдсан таван хүн тутмын хоёр нь л санал нийлж байна гэсэн хариултыг өгсөн нь энэ арга хэмжээг хүмүүс төдийлөн дэмжихгүй байх нь харагдаж байна.
- Охид, эмэгтэйчүүдтэй бэлгийн харилцаанд орохын тулд худалдаж авсан хүмүүст ял шийтгэл оноох (хамрагдагчдын 51.4 хувь нь), торгууль төлүүлэх (хамрагдагчдын 63.8 хувь нь) арга хэмжээ авах нь зүйтэй гэж үзэж байна.
- Харин охид, эмэгтэйчүүдтэй бэлгийн харилцаанд орохын тулд худалдаж авсан хүмүүст хорих ял оноох ёстой гэсэн асуултанд нийт судалгаанд хамрагдсан арван хүний дөрөв нь санал нийлж байна, гурав нь санал нийлэхгүй байна, гурав нь мэдэхгүй гэж хариулжээ.

Урьдчилан сэргийлэх болон цаашид авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- Судалгаанд хамрагдсан арван хүний найм нь энэ гэмт хэрэгтэй тэмцэх боломжтой гэж үзэж байна.
- Энэ гэмт хэрэгтэй тэмцэхэд судалгаанд хамрагдсан арван хүний тав нь мэдээлэл түгээх, гурав нь хохирогчдын талаар хууль хяналтын

байгууллагад мэдээлэл өгөх, хоёр нь шаардлага тавина, тэмцэнэ г.м өөр өөрсдийн аргаар хувь нэмрээ оруулах боломжтой гэж хариулсан байна.

- Нийт судалгаанд хамрагдагчдын 80.8 хувь нь энэ төрлийн гэмт хэргийг таслан зогсоох ёстой гэж үзэж байна.
- Энэ хэргийг таслан зогсоохын тулд дараах үйл ажиллагааг санал болгож

байна. Үүнд:

- Хууль, дүрэм, журмаа чангатгах;
- Олон нийтийн сүлжээгээр мэдээлэл явуулах;
- Холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах;
- Ажлын байр нэмэгдүүлэх;
- Биеэ үнэлэгчийг худалдан авч буй хүмүүст хариуцлага тооцох;
- Биеэ үнэлэгчдийг орогнуулдаг үйлчилгээний газруудыг илрүүлж хаах, болзошгүй газруудад байнга хяналт шалгалт хийж байх;
- Хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх
- Биеэ үнэлэгчдийг нийгэмшүүлэх зэрэг үйл ажиллагааг дурьджээ.
- Бүлгийн болон ганцаарчилсан ярилцлаганд оролцогчид өөрсдийгөө энэ төрлийн гэмт хэргийн хохирогчдод дараах төрлийн анхан шатны туслалцаа, үйлчилгээг үзүүлэх боломжтой гэсэн.

Үүнд:

- Холбон зуучлах;
- Сэтгэл зүйн зөвлөгөө;
- Хууль зүйн зөвлөгөө;
- Сургалт;
- Сурталчилгааны ажил зохион байгуулах


БҮЛЭГ 2

Судалгаанд хамрагдагчдын
хүн ам зүйн үзүүлэлтүүд

БҮЛЭГ 2. СУДАЛГААНД ХАМРАГДАГЧДЫН ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Энэ бүлэгт судалгааны асуулганд хамрагдсан хүмүүсийн хүн ам зүйн үзүүлэлтийг танилцуулж байна. Судалгаанд Улаанбаатар хотын 6 дүүрэг болон Дархан-Уул, Орхон, Замын-Үүд, Дорнод, Өмнөговь аймгаас нийт 710 хүн хамрагдаж, хамрагдалтын хувь 100 байлаа. Судалгаанд хамрагдагчдын хүйсийн харьцаа тэнцүү буюу 355 эрэгтэй, 355 эмэгтэй байна.

Зураг 2.1 Судалгаанд хамрагдагчдын бүтэц, байршлаар




Суурь судалгаанд хамрагдагчдын 52.8 хувь буюу 375 нь Улаанбаатар хотоос, 7.7 хувь буюу 55 нь Замын-Үүд сумаас, харин Дархан-Уул, Орхон, Дорнод, Өмнөговь аймгуудаас тус бүр 70 хүн хамрагдсан байна (Зураг 2.1).

Хүснэгт 2.1. Судалгаанд хамрагдсан хүний тоо, насны бүлэг, байршлаар

Насны бүлэг	Бүгд		Үүнээс: Байршлаар					
	Тоо	Хувь	Дархан-Уул	Орхон	Замын-Үүд	Дорнод	Өмнөговь	Улаанбаатар
Бүгд	710	100.0	9.9	9.9	7.7	9.9	9.9	52.8
16-19	20	100.0	30.0	0.0	15.0	5.0	0.0	50.0
20-24	79	100.0	16.5	11.4	6.3	6.3	6.3	53.2
25-29	145	100.0	8.3	11.7	10.3	8.3	7.6	53.8
30-34	149	100.0	7.4	9.4	11.4	14.8	10.1	47.0
35-39	125	100.0	8.8	9.6	8.8	12.0	8.8	52.0
40-44	90	100.0	7.8	16.7	3.3	12.2	14.4	45.6
45-49	42	100.0	7.1	7.1	0.0	2.4	14.3	69.0
50-54	25	100.0	8.0	0.0	0.0	4.0	20.0	68.0
55-59	23	100.0	8.7	0.0	4.3	8.7	17.4	60.9
60 ба түүнээс дээш	12	100.0	25.0	0.0	0.0	0.0	0.0	75.0

Судалгаанд хамрагдагчдыг насны бүлэг, байршлаар нь Хүснэгт 2.1-д, харин насны бүлгийн бүтцийг Зураг 2.2-т харуулж байна. Зураг 2.2-оос харахад нийт хамрагдагчдын 21.0 хувь буюу 149 нь 30-34, 20.4 хувь буюу 145 нь 25-29, 17.6 хувь буюу 125 нь 35-39, 12.7 хувь буюу 90 нь 40-44, 11.1 хувь буюу 79 нь 20-24, 5.9 хувь буюу 42 нь 45-49 настай, 8.5 хувь буюу 60 нь 50 ба түүнээс дээш насныхан байна.

Зураг 2.2 Судалгаанд хамрагдагчдын насны бүтэц



Судалгаанд 16-19 настай 20 залуус Улаанбаатар(10), Дархан-Уул(6), Замын-Үүд(3), Дорнод(1) аймгаас, харин 60 ба түүнээс дээш настай 12 хүн Улаанбаатар хот, Дархан-Уул аймгаас тус тус оролцсон байна.

Судалгаанд хамрагдагчдын 68.0 хувь буюу 484 нь дээд, 12.4 хувь буюу 88 нь бүрэн дунд, 8.0 хувь буюу 57 нь тусгай мэргэжлийн, 6.7 хувь буюу 47 нь техникийн болон мэргэжлийн, 2.3 хувь буюу 16 нь суурь, 2.0 хувь буюу 14 нь бага боловсролтой бол 0.6 хувь буюу 4 нь боловсролгүй хүмүүс байна (Хүснэгт 2.2). Энэхүү судалгааны түүвэрлэлт нь биеэ үнэлэлт, бэлгийн мөлжлөгийн хохирогчтой тодорхой хэмжээнд хүрч ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагын албан хаагчдаас мэдээлэл цуглуулсан учраас судалгаанд хамрагдагчдын дийлэнх нь дээд боловсролтой хүмүүс байгаа болно.


Хүснэгт 2.2

Судалгаанд хамрагдсан хүний тоо, боловсролын түвшин, хүйсээр, дүнд эзлэх хувиар

Үзүүлэлт	Бүгд		Үүнээс: хүйсээр	
	Тоо	Хувь	Эрэгтэй	Эмэгтэй
Дээд	484	68.2	67.0	69.3
Тусгай мэргэжлийн дунд	57	8.0	8.7	7.3
Техникийн болон мэргэжлийн	47	6.7	5.2	8.2
Бүрэн дунд	88	12.4	13.5	11.3
Суурь	16	2.3	2.8	1.7
Бага	14	2.0	2.5	1.4
Боловсролгүй	4	0.6	0.3	0.8
Дүн	Хувь		100.0	100.0
	Тоо	710	-	355


Судалгаанд хамрагдагчдын арван хүний нэг нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, зургаа нь төрийн албан хаагчид байна.

Зураг 2.3 Судалгаанд хамрагдагчдын ажил эрхлэлтийн байдлын бүтэц, хувиар



Судалгаанд хамрагдагчдын орлогын эх үүсвэрийг дараах Зураг 2.4-т үзүүлж байна. Нийт хамрагдагчдын 49.3 хувь нь төсвийн цалин, 25.2 хувь нь цалин, хөлс, 11.0 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлсэн орлого, 3.7 хувь буюу 26 хүн тэтгэвэр, тэтгэмж, 3.5 хувь буюу 25 хүн гэр бүлийн хүний цалингаар орлогын эх үүсвэрээ бүрдүүлж байгаа бол 5.4 хувь буюу 38 нь тогтмол орлогогүй хүмүүс байна.

Зураг 2.4 Судалгаанд хамрагдагчдын орлогын эх үүсвэрийн бүтэц, хувиар



Судалгаанд хамрагдсан нийт хүний 72.8 хувь буюу 517 нь гэрлэсэн, 20.7 хувь буюу 147 нь огт гэрлээгүй, 3.1 хувь буюу 22 нь гэрлэлтээ цуцалсан, харин үлдсэн хүмүүс нь тусгаарласан болон бэлэвсэн хүмүүс байна. Уг харьцаа мөн хүйсээр хадгалагдаж байгаа нь дараах хүснэгтээс ажиглагдаж байна (Хүснэгт 2.2). Гэрлэлтийн байдлыг хүйсээр нь авч үзэхэд: эрэгтэйчүүдийн 22.8 хувь нь гэрлээгүй бол эмэгтэйчүүд нь 4.2 пунктээр бага буюу 18.4 хувьтай байна. Харин гэрлэсэн эмэгтэйчүүдийн хувь нь эрэгтэйчүүдээс 4.4 пунктээр илүү буюу 75.5 хувьтай байна.


Судалгаанд хамрагдсан арван хүн тутмын хоёр нь хүүхэдгүй, тав нь 1-2 хүүхэдтэй, гурав нь 3 ба түүнээс дээш хүүхэдтэй хүмүүс байна. Хүүхэдгүй эрэгтэйчүүд нь эмэгтэйчүүдээсээ илүү байсан бол хүүхэдтэй эмэгтэйчүүдийн тоо хүүхэдтэй эрэгтэйчүүдээсээ илүү байгаа нь дараах хүснэгтээс харагдаж байна.

Хүснэгт 2.2 Судалгаанд хамрагдсан хүний тоо, хүйс, гэрлэлтийн байдал, хүүхэдтэй эсэхээр

	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Бүгд	710	100.0	355	100.0	355	100.0
Огт гэрлээгүй	147	20.7	81	22.8	66	18.6
Гэрлэсэн батлуулсан	395	55.6	189	53.2	206	58.0
Гэрлэсэн батлуулаагүй	122	17.2	60	16.9	62	17.5
Тусгаарласан	13	1.8	6	1.7	7	2.0
Цуцалсан	22	3.1	9	2.5	13	3.7
Бэлэвсэн	11	1.5	10	2.8	1	0.3
Бүгдээс:						
Хүүхэдгүй	135	19.0	72	20.3	63	17.7
1-2 хүүхэдтэй	393	55.4	194	54.6	199	56.1
3 ба түүнээс дээш хүүхэдтэй	182	25.6	89	25.1	93	26.2


Судалгаанд хамрагдагчдын 52.5 хувь буюу 373 нь уугуул оршин суугчид байгаа бол 20.2 хувь буюу 143 нь 5 ба түүнээс дээш жил, 19.6 хувь буюу 139 нь 1-5 жил, 7.7 хувь буюу 55 нь тухайн орон нутагтаа амьдраад жил хүрээгүй хүмүүс байлаа (Зураг 2.5).

Зураг 2.5 Одоогийн оршин сууж буй газраа хэр удаан амьдарч байгаа, жилээр



Судалгаанд хамрагдагчдаас шилжих хөдөлгөөнд оролцсон хүмүүсийн тухайн газраа шилжиж ирэхийн өмнө хаана оршин сууж байсан газрыг нь суурьшлаар гаргаж Зураг 2.6-д харуулж байна.

Зураг 2.6 Танайх өмнө нь хаана оршин сууж байсан бэ?, суурьшлаар



Тэдгээр хүмүүсийн 59.8 хувь буюу 198 нь аймгийн төвд, 20.8 хувь буюу 70 нь нийслэлд, 20.5 хувь буюу 69 нь сумдад амьдарч байсан байна.

Эдгээр шилжих хөдөлгөөнд орсон нийт 337 хүний 74.5 хувь буюу 251 нь одоогийн оршин сууж байгаа газартаа бүртгэл хийлгэсэн бол 25.5 хувь буюу 86 нь тухайн амьдарч буй орон нутагтаа бүртгэл хийлгээгүй хүмүүс байлаа. Амьдарч буй орон нутагтаа бүртгэл хийлгээгүй нийт хүний 33.7 хувь буюу 29 нь оршин сууж байгаа газартаа ирээд жил болоогүй, 52.3 хувь буюу 45 нь 1-5 жил, 14.0 хувь буюу 12 нь 5 ба түүнээс дээш жил амьдарч байгаа хүмүүс байна.

БҮЛЭГ 3

Биеэ үнэлэлт

БҮЛЭГ 3. БИЕЭ ҮНЭЛЭЛТ

Энэ бүлэгт биеэ үнэлэлтийн талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг, энэ гэмт хэрэг гарах болсон шалтгаан болон биеэ үнэлэлтийг хуульчлах, тэднийг худалдан авагч нарт ял шийтгэл оногдуулах асуудалд хандаж буй олон нийтийн байр суурь, чиг хандлагыг тодорхойлох зорилгоор чиглэсэн асуултын хариултыг бүлгийн, ганцаарчилсан ярилцлагууд болон судалгаанд хамрагдсан хүний тоогоор нэгтгэн танилцуулж байна.

3.1 Биеэ үнэлэлтийн талаарх олон нийтийн үзэл бодол

“Таны бодлоор танай орон нутагт биеэ үнэлэлт байдаг уу?” гэсэн асуултанд нийт судалгаанд хамрагдагдсан 379(53.4 %) хүн санал нийлж байна, 6.3 хувь буюу 45 хүн санал нийлэхгүй гэж хариулсан байна. Харин судалгаанд хамрагдсан арван хүний дөрөв нь энэ талаар ерөөсөө мэдэхгүй юм байна гэжээ (Хүснэгт 3.1).

Хүснэгт 3.1

Биеэ үнэлэлтийн талаарх судалгаанд хамрагдагчдын үзэл бодол, дүнд эзлэх хувиар

	Санал нийлж байна ¹	Санал нийлэхгүй байна ²	Мэдэхгүй
Таны бодлоор танай орон нутагт биеэ үнэлэлт байдаг уу?	53.4	6.3	40.3
Монголд биеэ үнэлэлтийг хууль ёсны болгох хэрэгтэй юу?	29.4	53.1	17.5
Насанд хүрэгчдэд бэлгийн харилцааг мөнгөөр худалдаж авах зөвшөөрөл олгох нь зөв үү?	12.1	68.7	19.2
Биеэ үнэлэлтийг хуулиар зөвшөөрвөл эрэлт нэмэгдэнэ.	26.3	44.8	28.9
Биеэ үнэлэлт аль ч нийгэмд байх л ёстой асуудал.	20.6	53.5	25.9
Биеэ үнэлэлтийг хуулиар зөвшөөрснөөр эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгт ашиглах явдлаас сэргийлж чадна.	28.3	43.2	28.5
Биеэ үнэлэлт саун, массаж, шөнийн цэнгээний газрууд гэлтгүй хаа сайгүй явагдаж байна.	72.3	6.5	21.2
Биеэ үнэлэлтийг хүлээн зөвшөөрвөл худалдан авагчдын тоо нэмэгдэнэ.	36.9	27.6	35.5

Харин бүлгийн болон ганцаарчилсан ярилцлаганд оролцогчид өөрсдийнхөө орон нутагт биеэ үнэлэлт, бэлгийн мөлжлөг ямар нэг хэмжээгээр байдаг гэдгийг хүлээн зөвшөөрсөн байна. Тэдний дийлэнх нь охид, эмэгтэйчүүд байгаа бөгөөд биеэ үнэлж байгаа гол шалтгаан нь ихэнхдээ амар хялбар аргаар мөнгө олох, гэр бүлийн таагүй нөхцөл байдал, гэр бүлийн хүчирхийлэл, архидалт нөгөө талаас МУ-д ажилгүйдэл, ядуурал их байгаатай холбоотой гэсэн байна. Мөн тэд орон нутгийн онцлог, нөхцөл байдлаас шалтгаалан биеэ үнэлэлт нэмэгдэж байна гэжээ.


Шигтгээ1:

Баянзүрх дүүрэг бол хүм ам, газар нутаг, аж ахуйн нэгж, их, дээд сургууль, коллеж, зочид буудлын тоогоороо УБ хотод тэргүүлэх хандлагатай байдаг. Түүнийгээ дагаад гэмт хэрэг, зөрчил ч их гардаг дүүрэг. Гэмт хэргийн нөхцөл байдлаараа хүнд, асуудалтай дүүрэг гэх үү дээ. Тэгэхээр биеэ үнэлэх явдал ч их байдаг гэсэн үг.

УБ хотын БЗД-т хийсэн бүлгийн ярилцлагаас

“Монголд биеэ үнэлэлт хэр их хэмжээнд байдаг вэ?” - гэсэн асуултанд нийт судалгаанд хамрагдагчдын 49.4 хувь буюу 351 хүн их, 18.6 хувь буюу 132 хүн маш их, 6.2 хувь буюу 44 хүн бага, 1.2 хувь буюу 8 хүн маш бага байдаг гэж хариулсан бол 24.6 хувь буюу 175 хүн мэдэхгүй гэж хариулжээ (Зураг 3.1). Дараах зургаас харахад судалгаанд хамрагдагчдын 68.0 хувь нь буюу 3 хүн тутмын 2 нь Монгол Улсад биеэ үнэлэлт их байдаг гэж үзсэн байна.

Зураг 3.1 Монголд биеэ үнэлэлт хэр их байдаг талаарх үзэл бодол, хувиар



Шигтгээ 2:


- Манай аймагт биеэ үнэлэлт жил ирэх тутам нэмэгдэж байна. Хөдөө орон нутгаас төв суурин газарт ирж их, дээд сургууль, МСҮТ-д суралцах, ажил хөдөлмөр эрхлэх гэсэн залуучууд нэмэгдэж байгаатай энэ нь холбоотой.
- Мөн сүүлийн үед Орхон аймагт хар тамхины хэрэглээ нэмэгдэж байгаа бөгөөд үүнийг дагаад биеэ үнэлэгчдийн тоо ч өсөх хандлагатай байна.

Орхон аймагт хийсэн бүлгийн ярилцлагаас...

Монголд биеэ үнэлэлт хэр их байдаг вэ? гэсэн асуултын хариултыг байршлаар авч үзэхэд аймгуудын хувьд Монголд биеэ үнэлэлт их байдаг гэж 27-35 хүн, маш их байдаг гэдэгт 8-14 хүн хариулсан байна.

Харин Улаанбаатар хотоос оролцогчд(нийт 375 хүн)-ын хоёр хүний нэг нь Монголд биеэ үнэлэлт их (190 хүн), таван хүний нэг нь маш их (79 хүн) байдаг гэж хариулжээ (Зураг 3.2).

Зураг 3.2 Монголд биеэ үнэлэлт хэр их байдаг талаарх үзэл бодол, байршлаар



Шигтгээ 3

- Энэ гэмт хэрэг хот, суурин газар буюу хүн ам төвлөрсөн газар илүү их үйлдэгдэж байна.
- Сүүлийн үед барилга, уул уурхай, зам тээврийг дагаад гэр орноосоо хол хөдөлмөр эрхлэж буй залуучууд нэмэгдэж байна. Үүнийг дагаад биеэ үнэлэлтийн асуудал их гарч байна.

УБ хотод хийсэн бүлгийн ярилцлагаас...


Шигтгээ 4

- Нүүрсний зам дагуу нүүрс тээвэрлэж буй жолооч нар их байдгаас түүнийг дагаад биеэ үнэлэлт байна.
- Ганц модны чиглэлд тээврийн жолооч нарын тооноос хамааран биеэ үнэлэлт зарим тохиолдолд ихсэж, заримдаа буурах хандлагатай байдаг.
- Тэдний ихэнх нь өөр орон нутгаас ирж биеэ үнэлдэг бөгөөд насны хувьд дийлэнх нь 25-аас дээш байдаг. 40 гарсан эмэгтэй ч энд энэ ажлыг хийж байна.

Өмнөговь аймгийн Гашуунсухайтад хийсэн ярилцлагаас....

Зураг 3.3


Монголд биеэ үнэлэлт хэр их байдаг талаарх үзэл бодол, ажил эрхлэлтийн байдлаар



Судалгаанд хамрагдсан 437 төрийн албан хаагчдын 51.7 хувь буюу 226 нь биеэ үнэлэлт их, 19.2 хувь буюу 84 нь маш их байдаг гэж хариулжээ. Мөн ТББ-ын ажилтан болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 22.4-22.5 хувь нь манай улсад биеэ үнэлэлт маш их байна гэсэн нь зургаас харагдаж байна. Дүгнэн хэлбэл судалгаанд оролцогчдын дийлэнх нь МУ-д, аль ч орон нутагт биеэ үнэлэлт их байна гэдгийг хүлээн зөвшөөрсөн байна.


“Монголд биеэ үнэлэлтийг хууль ёсны болгох хэрэгтэй юу?” гэсэн асуултанд 53.1 хувь буюу 377 хүн санал нийлэхгүй байна, 29.4 хувь буюу 209 хүн санал нийлж байна, харин 17.5 хувь буюу 124 хүн энэ талаар мэдэхгүй гэж хариулсан байна (Зураг 3.4). Хариултыг хүйсээр нь авч үзэхэд энэ хандлага ойролцоо байна (санал нийлэхгүй- 182 эрэгтэй, 195 эмэгтэй, санал нийлж байна- 108 эрэгтэй, 101 эмэгтэй). Үүнээс үзэхэд Монгол Улсад биеэ үнэлэлтийг хууль ёсны болгохыг судалгаанд хамрагдсан арван хүний гурав нь л зөвшөөрч байгааг харахад энэ асуудлыг хууль ёсны болгохыг дэмжихгүй байгаа нь ажиглагдаж байна.

Зураг 3.4 Монголд биеэ үнэлэлтийг хууль ёсны болгох хэрэгтэй юу?




“Насанд хүрэгчдэд бэлгийн харилцааг мөнгөөр худалдаж авах зөвшөөрөл олгох нь зөв үү?” гэсэн асуултанд нийт судалгаанд хамрагдагчдын 68.7 хувь (Хүснэгт 3.1) буюу арван хүний долоо нь санал нийлэхгүй байна гэж хариулсныг үзвэл манай оронд насанд хүрэгчдэд бэлгийн харилцааг мөнгөөр худалдаж авах зөвшөөрөл олгох нь буруу гэж үзэж байна. Насанд хүрэгчдэд бэлгийн харилцааг мөнгөөр худалдаж авах зөвшөөрөл олгох нь буруу гэсэн нийт 488 хүний 52.9 хувь буюу 258 нь эмэгтэйчүүд, 47.1 хувь буюу 230 нь эрэгтэйчүүд байгаа нь дараах зургаас харагдаж байна (Зураг 3.5).

Зураг 3.5 Насанд хүрэгчдэд бэлгийн харьцааг мөнгөөр худалдаж авах зөвшөөрөл олгох талаарх судалгаанд хамрагдагчдын үзэл бодол, хүйс, хүний тоогоор




“Биеэ үнэлэлтийг хуулиар зөвшөөрвөл эрэлт нэмэгдэнэ” гэсэн асуултанд 44.8 хувь буюу 318 хүн санал нийлэхгүй, 26.3 хувь буюу 187 хүн санал нийлж байна, 28.9 хувь буюу 205 хүн мэдэхгүй гэж хариулжээ (Зураг 3.6).

Зураг 3.6 Биеэ үнэлэлтийг хуулиар зөвшөөрвөл эрэлт нэмэгдэнэ




“Биеэ үнэлэлт нь аль ч нийгэмд байх л ёстой асуудал” гэсэн асуултанд арван хүн тутмын хоёр нь санал нийлж байгаа бол тав нь санал нийлэхгүй байна, гурав нь мэдэхгүй гэж хариулсан байна (Зураг 3.7).

Зураг 3.7 Биеэ үнэлэлт аль ч нийгэмд байх л ёстой асуудал




“Биеэ үнэлэлтийг хуулиар зөвшөөрснөөр эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгт ашиглах явдлаас сэргийлж чадна” гэсэн асуултанд 43.2 хувь буюу 307 хүн санал нийлэхгүй, 28.3 хувь буюу 201 хүн санал нийлж байна, 28.5 хувь буюу 205 хүн мэдэхгүй гэж хариулжээ (Зураг 3.8).

Зураг 3.8 Биеэ үнэлэлтийг хуулиар зөвшөөрснөөр эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгт ашиглах явдлаас сэргийлж чадна




“Биеэ үнэлэлт саун, массаж, шөнийн цэнгээний газрууд гэлтгүй хаа сайгүй явагдаж байна” гэсэн асуултанд 72.3 хувь буюу 513 хүн санал нийлж байна, 6.5 хувь буюу 46 хүн санал нийлэхгүй байна, 21.2 хувь буюу 151 хүн мэдэхгүй (Хүснэгт 3.1) гэж хариулсныг үзэхэд Монгол Улсад биеэ үнэлэлт саун, массаж, шөнийн цэнгээний газруудад голдуу явагддаг байна гэж үзэж болохоор байна. Дээрх асуултанд санал нийлж байгаа 513 хүний 51.1 хувь буюу 262 нь эрэгтэйчүүд, 48.9 хувь буюу 251 нь эмэгтэйчүүд байлаа (Зураг 3.9).

Зураг 3.9 Биеэ үнэлэлт саун, массаж, шөнийн цэнгээний газрууд гэлтгүй хаа сайгүй явагдаж байна гэсэнтэй санал нийлж байгаа эсэх талаарх судалгаанд хамрагдагчдын үзэл бодол, хүйсээр



“Биеэ үнэлэлтийг хүлээн зөвшөөрвөл худалдаж авагчдын тоо нэмэгдэнэ” гэсэн асуултанд 36.9 хувь буюу 262 хүн санал нийлж байна, 27.6 хувь буюу 196 хүн санал нийлэхгүй байна, 35.5 хувь буюу 252 хүн мэдэхгүй гэж хариулсан байна (Зураг 3.10). Өөрөөр хэлбэл арван хүн тутмын дөрөв нь биеэ үнэлэлтийг хүлээн зөвшөөрвөл худалдаж авагчдын тоо нэмэгдэнэ гэсэн бол гурав нь нэмэгдэхгүй, гурав нь мэдэхгүй гэжээ.

Зураг 3.10 Биеэ үнэлэлтийг хүлээн зөвшөөрвөл худалдан авагчдын тоо нэмэгдэнэ



“Таны бодлоор яагаад хүмүүс биеэ үнэлэхээр шийддэг вэ?, ямар шалтгаанууд байж болох вэ? гэсэн асуултанд бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагад оролцогчдын дийлэнх нь ажилгүйдэл, ядуурал, архидалт, гэр бүлийн таагүй нөхцөл байдал, гэр бүлийн хүчирхийлэл, хүмүүжил, залуучууд амар хялбар аргаар мөнгө олох зорилготой холбоотой гэсэн байна. Нөгөө хэсэг нь худалдан авалт байгаатай холбоотой гэжээ.

Зураг 3.11 Биеэ үнэлэх болсон шалтгааны бүтэц, судалгаанд хамрагдагчдын бодлоор, хувиар



Харин нийт судалгаанд хамрагдагчдын 34.5 хувь буюу 245 нь мөнгө олох, 15.9 хувь буюу 113 нь ажилгүйдлээс, 13.1 хувь буюу 93 нь ядуурлаас, 9.3 хувь буюу 66 нь хорихоос суллагдсанаас, хялбар аргаар амьдрах сонирхолтойгоос, 2.8 хувь буюу 20 нь хүндрэлтэй асуудлаа шийдэх гэж, 2.0 хувь буюу 14 нь нийгмийн хүнд байдлаас болж гэж хариулсан байна (Зураг 3.11). Бусад гэсэн шалтгаан дотор үүнээс өөр гарц байхгүй болохоор, ажлын байргүйгээс хүүхдүүд татагдан орж байна, өөрсдөө ийм ажил хийх дуртай болохоор, амьдралын шаардлагаар, бусдад зарагдаж гэх мэт шалтгаануудыг дурьдсан байна.

3.2 Биеэ үнэлэгчдийг худалдан авагч нарт ял, шийтгэл оногдуулах талаарх олон нийтийн чиг хандлага

Энэ хэсэгт биеэ үнэлэгчдийг худалдан авагч нарт ял, шийтгэл оногдуулах талаарх олон нийтийн санаа бодол, чиг хандлагыг тогтоох зорилгоор судалгаанд хамрагдагчдаас 7 асуулт асуусан бөгөөд хариултыг та бүхэнд танилцуулж байна.


“Биеэ үнэлэгчдийг худалдан авагч нарт хуулийн хариуцлага хүлээлгэх ёстой гэж үздэг үү?” гэсэн асуултанд судалгаанд хамрагдагчдын 70.7 хувь буюу 502 хүн санал нийлж байна, 13.6 хувь буюу 92 хүн санал нийлэхгүй байна, 16.3 хувь буюу 116 хүн мэдэхгүй гэж хариулсан байна(Хүснэгт 3.2). Биеэ үнэлэгчдийг худалдан авагч нарт хуулийн хариуцлага хүлээлгэх ёстой гэж үзэж байгаа хүмүүсийн 28.1 хувь буюу 141 хүн маш их санал нийлж байна гэжээ. Ийнхүү олонхын санал бодлоор эдгээр хүмүүст хуулийн хариуцлага хүлээлгэх нь зүйтэй гэж үзэж байна.

Хүснэгт 3.2 Биеэ үнэлэгчдийг худалдан авагч нарт хуулийн хариуцлага хүлээлгэх эсэх талаарх судалгаанд хамрагдагчдын үзэл бодол, дүнд эзлэх хувиар

	Санал нийлж байна	Санал нийлэхгүй байна	Мэдэхгүй
Биеэ үнэлэгчдийг худалдан авагч нарт хуулийн хариуцлага хүлээлгэх ёстой гэж үздэг үү?	70.7	13.0	16.3
Биеэ үнэлэлтийн талаарх өнөөгийн хууль тогтоомжид заасан хариуцлагууд оновчтой гэж та бодож байна уу?	14.1	48.6	37.3
Биеэ үнэлэгчдийг худалдаж авсны улмаас хуулийн хариуцлага хүлээж буй этгээдийн нэрийг олон нийтэд зарлах хэрэгтэй	40.3	35.4	24.3
Биеэ үнэлэгчийг худалдан авч буй хүнийг гэмт хэрэгтэн гэж бүртгэж авах ёстой	46.8	23.7	29.5
Охид, эмэгтэйчүүдтэй бэлгийн харилцаанд орохын тулд худалдаж авсан хүмүүст ял шийтгэл оноох ёстой	51.4	23.0	25.6
Охид, эмэгтэйчүүдтэй бэлгийн харилцаанд орохын тулд худалдаж авсан хүмүүс торгууль төлөх ёстой	63.8	21.4	14.8
Охид, эмэгтэйчүүдтэй бэлгийн харилцаанд орохын тулд худалдаж авсан хүмүүст хорих ял оноох хэрэгтэй	40.7	30.3	29.0


“Биеэ үнэлэлтийн талаарх өнөөгийн хууль тогтоомжид заасан хариуцлагууд оновчтой гэж та бодож байна уу?”- гэсэн асуултанд нийт хамрагдагчдын 48.0 хувь буюу 345 хүн санал нийлэхгүй, 14.1 хувь буюу 100 хүн санал нийлж байна гэж хариулсныг харахад биеэ үнэлэлтийн талаарх өнөөгийн хууль тогтоомжид заасан хариуцлагын арга хэмжээнүүд оновчтой бус хангалтгүй байна гэж үзэж байгаа болох нь харагдаж байна. Судалгаанд хамрагдсан арван хүний дөрөв нь энэ талаар мэдэхгүй гэж хариулжээ (Зураг 3.12).

Зураг 3.12 Биеэ үнэлэлтийн талаарх өнөөгийн хууль тогтоомжид заасан хариуцлагууд оновчтой гэж та бодож байна уу?



“Биеэ үнэлэгчдийг худалдаж авсны улмаас хуулийн хариуцлага хүлээж буй этгээдийн нэрийг олон нийтэд зарлах хэрэгтэй” гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан арван хүний дөрөв нь санал нийлж байна, зургаа (дөрөв нь санал нийлэхгүй, хоёр нь мэдэхгүй) нь санал нийлэхгүй, мэдэхгүй (Зураг 3.13) гэж хариулсныг үзэхэд энэ арга хэмжээ нэг их үр өгөөж өгөхгүй болох байдал ажиглагдаж байна.


Зураг 3.13 Биеэ үнэлэгчдийг худалдаж авсны улмаас хуулийн хариуцлага хүлээж буй этгээдийн нэрийг олон нийтэд зарлах хэрэгтэй гэсэн асуултанд судалгаанд хамрагдагчдын өгсөн хариулт, хувиар



“Биеэ үнэлэгчдийг худалдан авч буй хүнийг гэмт хэрэгтэн гэж бүртгэж авах ёстой”-гэсэн асуултанд нийт судалгаанд хамрагдагчдын 46.8 хувь буюу 332 хүн санал нийлж байна, 23.7 хувь буюу 168 хүн санал нийлэхгүй байна, 29.5 хувь буюу 210 хүн мэдэхгүй гэж хариулжээ. Үүнээс харахад судалгаанд хамрагдсан арван хүний хоёр нь л биеэ үнэлэгчдийг худалдан авч буй хүнийг гэмт хэрэгтэн гэж бүртгэх нь зүйтэй гэж үзэж байна.

“Охид, эмэгтэйчүүдтэй бэлгийн харилцаанд орохын тулд худалдаж авсан хүмүүст ял шийтгэл оноох ёстой” - гэсэн асуултанд 51.4 хувь буюу 365 хүн санал нийлж, 23.0 хувь буюу 163 хүн санал нийлэхгүй байна, 25.6 хувь буюу 182 хүн мэдэхгүй гэж хариулсан байна (Хүснэгт 3.2).


Зураг 3.14 Охид, эмэгтэйчүүдийг худалдаж авсан хүмүүст ял, шийтгэл оноох ёстой гэсэн олон нийтийн чиг хандлага, хувиар



Суурь судалгаанд хамрагдсан арван хүний дөрөв нь дээрх асуултанд санал нийлж байна гэсэн бол нэг нь маш их санал нийлж байна гэж хариултыг өгсөн байна (Зураг 3.14).

“Охид, эмэгтэйчүүдтэй бэлгийн харилцаанд орохын тулд худалдаж авсан хүмүүс торгууль төлөх ёстой” гэсэн асуултанд 63.8 хувь буюу 453 хүн санал нийлж, 21.4 хувь буюу 152 хүн санал нийлэхгүй байна, 14.8 хувь буюу 105 хүн мэдэхгүй гэж хариулсан байна. (Зураг 3.15).

Зураг 3.15 Охид, эмэгтэйчүүдтэй бэлгийн харилцаанд орохын тулд худалдаж авсан хүмүүс торгууль төлөх ёстой



Сүүлийн хоёр асуултын хариултаас харахад судалгаанд хамрагдагчид охид, эмэгтэйчүүдтэй бэлгийн харилцаанд орохын тулд худалдаж авсан хүмүүст ял шийтгэл оноохоос гадна тэдгээр хүмүүс торгууль төлөх нь зүйтэй гэж үзэж байна.

“Охид, эмэгтэйчүүдтэй бэлгийн харилцаанд орохын тулд худалдаж авсан хүмүүст хорих ял оноох ёстой” -гэсэн асуултанд 40.7 хувь буюу 289 хүн санал нийлж, 30.3 хувь буюу 215 хүн санал нийлэхгүй байна, 29.0 хувь буюу 206 хүн мэдэхгүй гэж хариулсан байна.

Биеэ үнэлэгчдийг худалдан авагч нарт ял шийтгэл оногдуулах талаарх судалгаанд хамрагдагчдын санал бодлыг дүгнэж үзэхэд:

- Биеэ үнэлэлтийн талаарх өнөөгийн хууль тогтоомжид заасан хариуцлагын арга хэмжээ нь оновчтой бус байна,
- Биеэ үнэлэгчдийг худалдан авагч нарт хариуцлага хүлээлгэх ёстой,
- Охид, эмэгтэйчүүдтэй бэлгийн харилцаанд орохын тулд худалдаж авсан хүмүүст ял оноох, торгууль төлүүлэх г.м хариуцлагын арга хэмжээ авах нь зүйтэй гэж үзэж байна..

БҮЛЭГ 4


Бэлгийн мөлжлөг

БҮЛЭГ 4. БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ

Энэ бүлэгт бэлгийн мөлжлөгийн талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг энэ гэмт хэргийн хохирогчийн талаарх олон нийтийн байр суурь, чиг хандлагыг тодорхойлох зорилгоор чиглэсэн асуултын хариултыг бүлгийн ярилцлага болон судалгаанд хамрагдсан хүний тоогоор нэгтгэн танилцуулж байна.

Судалгаанд хамрагдсан нийт хүн амын 81.0 хувь буюу 575 хүн бэлгийн мөлжлөгийн талаар сонсож байсан, 19.0 хувь буюу 135 хүн энэ талаар сонсож байгаагүй гэсэн дүн гарсан байна (Зураг 4.1).

Зураг 4.1 Бэлгийн мөлжлөгийн талаар сонсож байсан эсэх, байршлаар, хувиар



Бэлгийн мөлжлөгийн талаар хот, суурин газруудын арван хүн тутмын наймаас есөн хүн сонссон байхад Өмнөговь, Замын -Үүдэд зургаагаас долоо хүн л сонссон гэж хариулсан байна. Үүнээс үзэхэд хот, суурин газрын хүмүүсийн энэ талаарх мэдлэг хөдөө орон нутгийнхаас арай илүү байгаа нь дээрх зургаас харагдаж байна.

Харин бүлгийн ярилцлаганд оролцогчид энэ гэмт хэргийн талаарх мэдээллийг олон эх сурвалжаас авч байна гэсэн. Тухайлбал:

- Цахим мэдээллийн сүлжээ
- Улсын болон орон нутгийн чанартай олон нийтийн мэдээллийн хэрэгсэл
- Хүмүүсийн ам дамжсан яриа

- Зурагт хуудас, брошюр
- Сургалт, сурталчилгаа

Гэхдээ дийлэнх мэдээллийг цахим мэдээллийн сүлжээгээр авч байгаа учраас мэдээлэл нь бодитой эсэх нь эргэлзээтэй гэж үзэж байлаа.

“Таны бодлоор танай орон нутагт бэлгийн мөлжлөг үйлдэгддэг үү?”- гэсэн асуултанд 53.6 хувь буюу 382 хүн мэдэхгүй, 40.6 хувь буюу 288 хүн санал нийлж байна, 5.6 хувь буюу 40 хүн санал нийлэхгүй байна гэсэн хариулт өгчээ (Хүснэгт 4.1). Энэ асуултын хариултыг хүйсээр нь авч үзэхэд энэ асуудлын талаарх ойлголтод онцын ялгаа ажиглагдсангүй ижил түвшинд байлаа.

Хүснэгт 4.1 Бэлгийн мөлжлөгийн талаарх судалгаанд хамрагдагчдын үзэл бодол, дүнд эзлэх хувиар

	Санал нийлж байна	Санал нийлэхгүй байна	Мэдэхгүй
Таны бодлоор танай орон нутагт бэлгийн мөлжлөг үйлдэгддэг үү?	40.6	5.6	53.8
Биеэ үнэлэлт бол бэлгийн мөлжлөгийн нэг хэлбэр юм	56.1	16.1	27.8
Хүний наймаачид ихэвчлэн эмзэг бүлгийн охид, эмэгтэйчүүдийг худалддаг	74.6	7.7	17.7
Биеэ үнэлж буй охид, эмэгтэйчүүдийн дийлэнх нь өмнө нь бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэргийн хохирогч болсон байдаг	45.9	11.5	42.6
Хүний наймаачид нь сул дорой, эмзэг хэн нэгнийг өөрсдийн орлого олох эх үүсвэрээ болгон ашигладаг	76.1	4.4	19.5
Биеэ үнэлж буй охид, эмэгтэйчүүдийн дийлэнх нь энэ байдлаасаа “зугтах”-ыг хүсдэг ч хэнээс, хаанаас тусламж авахаа мэддэггүй	59.3	12.8	27.9

“Биеэ үнэлэлт бол бэлгийн мөлжлөгийн нэг хэлбэр юм” -гэсэн асуултанд судалгаанд хамрагдагчдын 56.1 хувь буюу 398 хүн санал нийлж байна, 16.1 хувь буюу 114 хүн санал нийлэхгүй байна, 27.8 хувь буюу 198 хүн мэдэхгүй гэж хариулжээ.

Харин бүлгийн ярилцлаганд оролцогчид биеэ үнэлэлт, бэлгийн мөлжлөгийг 2 өөр ойлголт гэж үзсэн байна. Тиймээс бэлгийн мөлжлөг биеэ үнэлэлтийг бодвол харьцангуй бага үйлдэгддэг гэжээ. Харин зарим нь бэлгийн мөлжлөгийг огт сонсоогүй гэсэн байна.

Шигтгээ 4:

Өөрийн хүсэл сонирхлоороо бусадтай бэлгийн харьцаанд орж, төлбөр авч байгаа нь биеэ үнэлэлт, харин өөрийнх нь эсрэг эрх чөлөөнд нь халдаж ийм үйлдэл хийлгүүлж байгаа бол үүнийг бэлгийн мөлжлөг гэж ойлгож байгаа. Ялгаа нь эндээ л байгаа даа.

УБ хотын БЗД-т хийсэн бүлгийн ярилцлагаас....


Шигтгээ 5:

Биеэ үнэлэлт сайн дурын байдаг бол бэлгийн мөлжлөг албадлагын шинжтэй. Одоогийн байдлаар манай аймагт бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг бүртгэгдээгүй.

Дорнод аймагт хийсэн бүлгийн ярилцлагаас

“Хүний наймаачид ихэвчлэн эмзэг бүлгийн охид, эмэгтэйчүүдийг худалддаг” гэсэн асуултанд 74.6 хувь буюу 530 хүн санал нийлж байна, 7.7 хувь буюу 55 хүн санал нийлэхгүй байна, 17.7 хувь буюу 125 хүн мэдэхгүй гэсэн байна. Харин санал нийлж байна гэж хариулсан хүмүүсийн 18.7 хувь буюу 99 хүн маш их санал нийлж байна гэж хариулжээ. Ер нь хүний наймаачид ихэвчлэн эмзэг бүлгийн охид, эмэгтэйчүүдийг худалддаг асуудал манай оронд ч бас их байдаг болох нь анзаарагдаж байна (Зураг 4.2).

Зураг 4.2 Хүний наймаачид ихэвчлэн эмзэг бүлгийн охид, эмэгтэйчүүдийг худалддаг



Шигтгээ 6:


- *Биеэ үнэлж байгаа охид, эмэгтэйчүүдийн ихэнх хувийг 18-25 насныхан эзэлж байна.*

Орхон аймагт хийсэн бүлгийн ярилцлагаас....

“Биеэ үнэлж буй охид, эмэгтэйчүүдийн дийлэнх нь өмнө нь бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэргийн хохирогч болсон байдаг” - гэсэн асуултанд нийт хамрагдагчдын 45.9 хувь буюу 326 хүн санал нийлж байна, 11.5 хувь буюу 82 хүн санал нийлэхгүй байна, 42.6 хувь буюу 302 хүн мэдэхгүй гэж хариулжээ.

“Хүний наймаачид нь сул дорой, эмзэг хэн нэгнийг өөрсдийн орлого олох эх үүсвэрээ болгон ашигладаг” - гэсэн асуултанд судалгаанд хамрагдагчдын 76.1 хувь буюу 540 хүн санал нийлж байна, 4.4 хувь буюу 31 хүн санал нийлэхгүй байна, 19.5 хувь буюу 139 хүн мэдэхгүй гэсэн байна. Санал нийлж байна гэж байгаа хүмүүсийн 17.8 хувь буюу 96 хүн маш их санал нийлж байна гэж хариулжээ.

Зураг 4.3 Хүний наймаачид нь сул дорой, эмзэг хэн нэгнийг өөрсдийн орлого олох эх үүсвэрээ болгон ашигладаг



Харин бүлгийн ярилцлагад оролцогчид энэ гэмт хэрэгт дараах бүлгийн хүмүүс илүү их өртөж, хохирогч болж байна гэжээ. Үүнд:

- Бага насандаа хүчирхийлэлд өртөж байсан
- Хараа хяналт багатай гэр бүлийн орчинд өссөн
- Сургууль завсардсан буюу боловсрол багатай
- Гэр бүлийн амьдралын нөхцөл муу
- Хагас болон бүтэн өнчин

- Гэр бүлийн хүчирхийлэлтэй орчинд өссөн

Өөрөөр хэлбэл эмзэг бүлгийн охид, эмэгтэйчүүд энэ гэмт хэрэгт их өртөж байна гэж дүгнэсэн байна. Мөн эрэгтэй хүүхэд ч гэсэн биеэ үнэлж байна гэсэн аман яриа их гарч байна гэжээ.

Шигтгээ 7:

2019 оны эхний хагас жилийн байдлаар “Хүүхдийн тусламжийн утас” 108-д гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхдийн эрхийн зөрчилтэй холбоотой нийт 167, бусад эх сурвалжаас 17 буюу нийт 184 дуудлага, мэдээлэл бүртгэгджээ. Үүнээс: гэр бүлийн хүчирхийлэл, архидалттай холбоотой 71 дуудлага бүртгэгдсэн байна. Хүчирхийллийн хэлбэр нь:

- Үл хайхрах- 137
- Бие махбодийн -30
- Бэлгийн хүчирхийлэл -5
- Сэтгэл санааны хүчирхийлэл -12 байсан байна.

Нийт хохирогчдын 67.4 хувь буюу 319 нь хүүхэд, 32.6 хувь буюу 154 нь насанд хүрэгчид байжээ.

УБ хотод хийсэн бүлгийн ярилцлагаас...

“Биеэ үнэлж буй охид, эмэгтэйчүүдийн дийлэнх нь энэ байдлаасаа “зугтах”-ыг хүсдэг ч хэнээс, хаанаас тусламж авахаа мэддэггүй” гэсэн асуултанд судалгаанд хамрагдагчдын 59.3 хувь буюу 421 хүн санал нийлж байна, 12.8 хувь буюу 91 хүн санал нийлэхгүй байна, 27.9 хувь буюу 198 хүн мэдэхгүй гэж хариулсан байна.

“Та хэн нэгнийг бэлгийн мөлжлөгийн хохирогч болсоныг мэдвэл хаана хандах вэ? гэсэн асуултанд нийт судалгаанд хамрагдагчдын 72.5 хувь буюу 515 нь цагдаад, 11.5 хувь буюу 84 нь хүүхдийн тусламжийн утас 108, 2.5 хувь буюу 18 нь Хүйсийн тэгш эрхийн төв рүү буюу хүн худалдаалах гэмт хэргийн асуудлаар урьдчилан сэргийлэх мэдээлэл, зөвлөгөө өгдөг 1800-1903 утсанд хандана гэж хариулжээ.

Харин бүлгийн ярилцлаганд оролцогчдын хувьд: энэ гэмт хэрэгт өртсөн хохирогчдод туслалцаа үзүүлэх талаар энэ чиглэлээр ажилладаг цагдаа, шүүгч, өмгөөлөгч, нийгмийн ажилтан, гэр бүл, хүүхдийн асуудлаар ажилладаг албан тушаалтнууд нь тодорхой хэмжээний мэдлэг, ойлголттой гэсэн бол олон нийтийн төлөөлөл өөрсдийгөө хангалттай мэдлэг, мэдээлэлгүй гэжээ.

Тэд энэ төрлийн гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлдэг байгууллага ховор байна. Тийм учраас энэ төрлийн гэмт хэрэгт өртсөн хохирогчид тэр бүр хандаад байдаггүй. Дийлэнх нь цагдаад ханддаг байх гэсэн байна.

“Та урьдчилан сэргийлэх мэдээлэл, анхааруулгыг ямар байдлаар хүлээж авахыг хүсэж байна вэ? гэсэн асуултанд нийт судалгаанд хамрагдагчдын 28.0 хувь буюу 199 хүн цахим орчин, 22.0 хувь буюу 156 хүн телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, 19.2 хувь буюу 136 хүн мэдээ, мэдээллээр хангах, 5.6 хувь буюу 40 хүн баг, хорооны сургалт, 3.2 хувь буюу 23 хүн утсаар, 2.8 хувь буюу 20 хүн жигшүүлэх, 2.4 хувь буюу 17 хүн сургуулиудад сургалтаар, 2.4 хувь буюу 17 нь компани үйл ажиллагаа, 2.1 хувь буюу 15 хүн тараах материал, 2.1 хувь буюу 15 хүн бодит мэдээлэл хүлээн авмаар байна гэж хариулжээ (Зураг 4.4).

Бүлгийн ярилцлаганд оролцогчид ялангуяа энэ гэмт хэргээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд зориулсан мэдээлэл, нэвтрүүлэг, хэвлэл мэдээллийн хэрэгслээр хангалттай гардаггүй гэсэн байна. Харин энэ чиглэлээр ажилладаг мэргэжилтнүүд сургалт, үйл ажиллагаанд хамрагдах замаар мэдээлэл, ойлголт авдаг гэжээ.

Зураг 4.4 Судалгаанд хамрагдагчдын хүсэж буй урьдчилан сэргийлэх мэдээллийн хэлбэрийн төрлийн бүтэц, хувиар



Мөн тэдний анхааруулж хэлж буй гол асуудал нь төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан бодит мэдээлэл өгөх үйл ажиллагааг тогтвортой явуулах хэрэгтэй. Гэхдээ мэдээллийн агуулга олон нийтэд айдас төрүүлэхээсээ илүү мэдлэг олгоход чиглэсэн байвал илүү үр дүнтэй гэж хариулсан байна.

Шигтгээ 8:

- Энэ талаарх мэдээллийг олон нийтэд түгээхдээ болгоомжтой хандахгүй бол олон нийтийг цочроох аюултай. Тухайлбал манай аймагт их, дээд сургуульд сурч буй охид, эмэгтэйчүүд олноор биеэ үнэлэж байна гээд олон нийтэд мэдээлчихвэл, тэнд суралцаж буй бүх охид, эмэгтэйчүүдийг буруутгах шинжтэй асуудал гарч магадгүй.....

Дорнод аймагт хийсэн бүлгийн ярилцлагаас

БҮЛЭГ 5


Урьдчилан сэргийлэх болон
цаашид авч хэрэгжүүлэх
үйл ажиллагаа

БҮЛЭГ 5. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БОЛОН ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Энэ бүлэгт биеэ үнэлэлт, бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх болон тэмцэх, таслан зогсоох үйл ажиллагааны талаарх санал бодол, энэ гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоох үйл ажиллагаанд таны оролцоо юу байна вэ? гэсэн асуудлуудын хариултыг тусгалаа.

“Энэ гэмт хэрэгтэй тэмцэх боломжтой юу? - гэсэн асуултанд нийт судалгаанд хамрагдагчдын 83.7 хувь буюу 594 хүн санал нийлж байна, 4.3 хувь буюу 31 хүн санал нийлэхгүй байна, 12.0 хувь буюу 85 хүн мэдэхгүй гэж хариулсан байна. Өөрөөр хэлбэл судалгаанд хамрагдсан хүмүүсийн дийлэнх олонх нь буюу 83.7 хувь энэ гэмт хэрэгтэй тэмцэх боломжтой гэсэн байна.

Зураг 5.1 Энэ гэмт хэрэгтэй тэмцэх боломжтой гэж хариулсан хүний саналын бүтэц, байршлаар, хувиар



Энэ гэмт хэрэгтэй тэмцэх боломжтой гэж хариулсан нийт 594 хүний 27.6 хувь буюу 164 нь маш их санал нийлж байна гэсэн бөгөөд байршлаар нь авч үзвэл Дархан-Уул аймагт судалгаанд хамрагдсан арван хүн тутмын бараг дөрөв нь, Дорнод, Орхон аймгуудад хоёр нь, харин Өмнөговь, Дорноговь аймгийн Замын-Үүд сум, Улаанбаатар хотод гурав нь маш их санал нийлж байна гэж хариулсан байна.

Бүлгийн болон ганцаарчилсан ярилцлаганд оролцогчид өөрсдийгөө энэ төрлийн гэмт хэргийн хохирогчдод анхан шатны туслалцаа, үйлчилгээг үзүүлэх боломжтой гэсэн байна. Тэд тусламж, үйлчилгээ хүсэж хандсан хохирогчдод дараах үйлчилгээг үзүүлж байсан байна. Үүнд:


- Холбон зуучлах үйлчилгээ
- Сэтгэлзүйн зөвлөгөө
- Хуульзүйн зөвлөгөө
- Сургалт
- Сурталчилгааны ажил зохион байгуулах г.м

Гэхдээ тэдний хохирогчдод үзүүлж буй үйлчилгээ нь анхан шатны туслалцаа, дэмжлэгээр хязгаарлагдаж байсан гэсэн байна.

Харин ганцаарчилсан ярилцлаганд хамрагдсан бүх хүн энэ төрлийн гэмт хэргийн хохирогчдод туслалцаа үзүүлэх талаар өөрсдийгөө “Маш сайн”, “Сайн” мэдлэг, туршлагатай гэжээ.

“Энэ гэмт хэрэгтэй тэмцэхэд та хувь нэмрээ хэрхэн оруулах боломжтой вэ? - гэсэн асуултанд нийт судалгаанд хамрагдагчдын 47.9 хувь буюу 340 хүн олон нийтэд мэдээлэл түгээх, 31.6 хувь буюу 224 хүн хохирогчдын талаар хууль хяналтын байгууллагад мэдээлэл өгөх, 15.6 хувь буюу 111 хүн шаардлага тавина, тэмцэнэ гэж хариулсан байна. Харин хүйсээр нь авч үзвэл: мэдээлэл түгээх нийт хүний 53.2 хувь буюу 181 нь эмэгтэйчүүд байсан бол шаардлага тавьж, тэмцэнэ гэсэн нийт хүний 63.1 хувь буюу 70 нь эрэгтэйчүүд байна.

Зураг 5.2 Гэмт хэрэгтэй тэмцэхэд судалгаанд хамрагдагчдын оруулах хувь нэмэр, төрлөөр, хувиар



“Та энэ төрлийн гэмт хэргийг таслан зогсоох ёстой гэж үзэж байна уу? гэсэн асуултанд нийт судалгаанд хамрагдагчдын 80.8 хувь буюу 574 хүн санал нийлж байна, 3.4 хувь буюу 24 хүн санал нийлэхгүй, 15.8 хувь буюу 112 хүн мэдэхгүй гэж хариулжээ. Энэ төрлийн гэмт хэргийг таслан зогсоох ёстой гэж үзэж байгаа хүмүүсийн дунд хүйсийн ялгаа байхгүй ижил түвшинд саналаа өгсөн байна. Харин нийт таслан зогсоох саналтай хүний 30.1 хувь буюу 173 нь маш их санал нийлж байна гэжээ.

“Хэрэв тийм бол ямар үйл ажиллагаа явуулбал үр дүнтэй гэж үзэж байна вэ? -гэсэн асуултанд олон төрлийн үйл ажиллагаануудыг дурьдсан байсан бөгөөд эдгээрийг эрэмбэлж нэгтгэн дараах зургаар харуулж байна.

Судалгаанд хамрагдагчдын 13.9 хувь буюу 99 хүн энэ асуултанд ямар нэг санал дэвшүүлээгүй байна.

Зураг 5.3 Гэмт хэргийг таслан зогсоохын тулд явуулах үйл ажиллагааны төрөл, судалгаанд оролцогчдын үзэл бодлоор



Нийт судалгаанд хамрагдагчдын 19.6 хувь буюу 139 хүн хууль, дүрэм журмаа чангатгах, 7.6 хувь буюу 54 хүн олон нийтийн сүлжээгээр мэдээлэл явуулах, 6.9 хувь буюу 49 хүн холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах гэж саналаа дэвшүүлсэн байна. Үүнээс гадна ажлын байр нэмэгдүүлэх(4.5 хувь), цалин хөлсөө нэмэгдүүлэх(4.5 хувь), эдийн засгаа сайжруулах(2.1 хувь) гэх мэт улс орны нийгэм, эдийн засгийн байдал сайжрах юм бол энэ гэмт хэрэг байхгүй болно гэж үзэж байгаа хүмүүс ч байна. Харин биеэ үнэлэгч, худалдан авагч нарт ял шийтгэл оноох, хууль гаргах, тэднийг орогнуулдаг баар, караоке, буудлыг илрүүлж хаах, хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх, биеэ үнэлэгчдийг нийгэмшүүлэх зэрэг цаашид авч хэрэгжүүлбэл зохих саналуудыг дэвшүүлсэн байна.

“Таны бодлоор энэ гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд танай орон нутагт ямар үйл ажиллагаа явуулбал үр дүнтэй вэ?” – гэсэн асуултанд бүлгийн болон ганцаарчилсан ярилцлаганд оролцогчид орон нутагт гэхээсээ илүү улсын хэмжээнд олон нийтийг энэ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хохирогчид үйлчилгээ үзүүлэх цогц, системтэй бодлого, хөтөлбөртэй байх хэрэгтэй гэсэн байна. Мөн дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулбал илүү үр дүнтэй гэсэн байна. Үүнд:

- Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй байгууллага бүр энэ асуудлаар хамтран ажиллах
- Олон нийт болон хохирогчдод мэдээлэл, зөвлөгөө өгдөг цэгүүдийг эрсдэл өндөртэй орон нутагт байгуулах
- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд тогтвортой мэдээлэл, ойлголт өгөхөд чиглэсэн ярилцлага, нэвтрүүлэг, шторк цацах
- ЕБС, их, дээд сургууль, МСҮТ-д суралцагчдад тогтмол мэдээлэл өгөх үйл ажиллагаа зохион байгуулах
- Энэ чиглэлээр ажилладаг мэргэжилтнүүдийг тогтвортой ажиллуулж, чадавхижуулах
- Алслагдсан сум, баг, гэр хорооллын иргэдийн дунд хүрч очин явууллын мэдээлэл өгөх үйлчилгээ нэвтрүүлэх, энэ чиглэлээр ажиллах ажилтнуудыг бэлтгэх, чадавхижуулах
- Олон нийтэд сургалт, сурталчилгаа зохион байгуулах
- Иргэдтэй хамгийн ойр ажилладаг баг, хорооны ажилтнуудыг сургах, чадавхижуулах
- Биеэ үнэлэгчид болон худалдан авагчдад хариуцлага тооцох гэх мэтээр урьдчилан сэргийлэх болон хамгаалах үйл ажиллагааг өргөн хүрээнд явуулах хэрэгтэй гэсэн байна.

Шигтгээ 9:

Хилийн бүс орчим олон нийтэд шууд хүрч очиж мэдээлэл, зөвлөгөө өгдөг, үйлчилгээ үзүүлдэг байгууллага хэрэгтэй байна.

Ганцаарчилсан ярилцлагаас

“Таны бодлоор биеэ үнэлэлтээс урьдчилан сэргийлэх эсвэл энэ гэмт хэрэгт өртөх эрсдэлтэй хүмүүст туслахад ямар төрлийн үйл ажиллагаа, арга хэмжээ илүү үр дүнтэй вэ?”-гэсэн асуултанд ганцаарчилсан асуулганд хамрагдсан хүмүүс дараах саналыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- Урьдчилан сэргийлэх чиглэлээр эрсдэлт бүлгийнхэнд чиглэсэн сургалт хийх

- Хилээр гарахаас өмнө эрсдэлт бүлгийг мэдээллээр хангах, ярилцлага хийх
- Тодорхой цэгүүдэд компанит ажил зохион байгуулах
- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтвортой мэдээлэл, ойлголт өгөхөд чиглэсэн ярилцлага, нэвтрүүлэг, шторк цацах
- Эрэгтэйчүүдэд мэдээлэл өгөх, ялангуяа хилийн бүс орчимд байгаа хүн болон бараа тээвэрлэж буй жолооч нарт чиглэсэн үйл ажиллагаа
- Үйлчилгээ авахаар ирж буй хохирогчтой ажиллах ажилтнуудыг чадавхижуулах

Хамгийн гол нь эдгээр орон нутгуудад хийгдэж буй үйл ажиллагаа тогтвортой байх хэрэгтэй гэсэн байна.

Шигтгээ 10:

- *Өрх бүртэй тулж ажилладаг, анхан шатны мэдээлэл, туслалцаа үзүүлэх боломжтой ажилтан бол сум, дүүргийн баг, хорооны ажилтан байдаг. Баг, хорооны ажилтнуудтай хамтран энэ асуудлаар тухайн газарт оршин сууж байгаа хүмүүст ойлголт, мэдээлэл өгөх үйл ажиллагаа явуулах хэрэгтэй байна.*

Бүлгийн ярилцлагаас

“Ямар үйл ажиллагаа зохион байгуулбал та оролцох боломжтой вэ? – гэсэн асуултанд нийт судалгаанд хамрагдагчдын 86.3 хувь буюу 613 хүн саналаа ирүүлсэн байна. Нийт хамрагдагчын 18.3 хувь буюу 130 хүн жагсаал, санал асуулганд, 17.6 хувь буюу 125 хүн бүх үйл ажиллагаанд оролцох боломжтой, 10.7 хувь буюу 76 хүн бүх үйл ажиллагааг дэмжиж орно, 9.4 хувь буюу 67 хүн мэдээлэл сурталчилгааг түгээх, 1.8 хувь буюу 13 хүн хуулийн хүрээнд оролцох, 1.7 хувь буюу 12 хүн биеэ үнэлэлтийн эсрэг бүх үйл ажиллагаанд оролцох боломжтой гэж хариулсан байна.

БҮЛЭГ 6

Дүгнэлт, зөвлөмж

БҮЛЭГ 6. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Судалгааны дүнгээр орон нутагт биеэ үнэлэлт, бэлгийн мөлжлөг ямар нэг хэмжээгээр байдаг гэдгийг судалгаанд оролцогчид хүлээн зөвшөөрч байна. Тэд ихэнхдээ амар хялбар аргаар мөнгө олох, гэр бүлийн таагүй нөхцөл байдал, архидалт нөгөө талаас ажилгүйдэл, ядууралтай холбоотойгоор хүмүүс биеэ үнэлж байна гэж үзсэн бөгөөд биеэ үнэлэгчдийн дийлэнх нь эмзэг бүлгийн охид, эмэгтэйчүүд байна гэж байсан. Энэ гэмт хэрэг хот, суурин газар буюу хүн ам төвлөрсөн газар илүү үйлдэгдэж байгаагаас гадна сүүлийн үед барилга, уул уурхай, зам тээврийг дагаад гэр орноосоо хол ажил хөдөлмөр эрхлэж буй залуусын тоо нэмэгдэж байгаатай уялдан биеэ үнэлэлтийн асуудал их гардаг боллоо гэсэн хандлагатай байна. Ийнхүү орон нутгийн онцлог, нөхцөл байдлаас шалтгаалан биеэ үнэлэлт нэмэгдэж байна гэж бүлгийн болон ганцаарчилсан ярилцлаганд оролцогчид үзэж байгаа бол судалгаанд хамрагдагчдын 68.0 хувь нь Монгол Улсад биеэ үнэлэлт их байдаг гэсэн үзэл бодолтой байна. Судалгааны дүнгээр манай оронд биеэ үнэлэлт саун, массаж, шөнийн цэнгээний газруудад голдуу явагдаж байна гэсэн дүн гарлаа.

Судалгаанд хамрагдагчид биеэ үнэлэлтийг Монгол Улсад хууль ёсны болгох асуудлыг дэмжихгүй байгаагаас гадна насанд хүрэгчдэд бэлгийн харилцааг мөнгөөр худалдаж авах зөвшөөрөл олгох нь буруу гэж үзэж, биеэ үнэлэлт нь аль ч нийгэмд байх л ёстой асуудал гэдэгтэй судалгаанд хамрагдагчдын дийлэнх нь санал нийлэхгүй байна. Харин биеэ үнэлэх болсон шалтгааныг мөнгө олох, ажилгүйдэл, ядуурал, архидалт, гэр бүлийн таагүй нөхцөл байдал, гэр бүлийн хүчирхийлэл, хүмүүжил, хүндрэлтэй асуудлаа шийдэх, залуучууд амар хялбар аргаар мөнгө олох зорилготой холбон тайлбарлаж байна.

Судалгаанд хамрагдсан арван хүний тав нь биеэ үнэлэлтийн талаарх өнөөгийн хууль тогтоомжид заасан хариуцлагын арга хэмжээнүүд оновчтой бус хангалтгүй, дөрөв нь мэдэхгүй гэж хариулсан бол судалгаанд хамрагдагчдын 70.7 хувь нь биеэ үнэлэгчдийг худалдан авагч нарт хуулийн хариуцлага хүлээлгэх нь зүйтэй гэж үзэж байна. Биеэ үнэлэгчдийг худагдаж авсны улмаас хуулийн хариуцлага хүлээж буй этгээдийн нэрийг нийтэд зарлах, биеэ үнэлэгчдийг худалдан авч буй хүнийг гэмт хэрэгтэн гэж бүртгэж авах ёстой гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан таван хүний хоёр нь л тус тус санал нийлж байна гэж хариулсныг үзэхэд хүмүүсийн бодлоор энэ тийм ч оновчтой арга хэмжээ биш болох нь ажиглагдаж байна. Харин охид, эмэгтэйчүүдтэй бэлгийн харилцаанд орохын тулд худалдаж авсан хүмүүст ял оноох (51.4 хувь), торгууль төлүүлэх (63.8 хувь) нь зүйтэй гэж үзэж байна.

Судалгаанд хамрагдагчдын 81.0 хувь нь бэлгийн мөлжлөгийн талаар сонсож байсан гэжээ. Тэд энэ гэмт хэргийн талаарх мэдээллийг дараах эх сурвалжаас авсан гэж хариуллаа. Үүнд:

- Цахим мэдээллийн сүлжээ
- Улсын болон орон нутгийн чанартай олон нийтийн мэдээллийн хэрэгсэл
- Хүмүүсийн ам дамжсан яриа
- Зурагт хуудас, брошюр
- Сургалт, сурталчилгаа

Гэхдээ дийлэнх мэдээллийг цахим мэдээллийн сүлжээгээр авч байгаа тул бодитой эсэх нь эргэлзээтэй гэдгийг анхааруулж байсан.

Судалгаанд хамрагдсан хоёр хүний нэг нь биеэ үнэлэлт бол бэлгийн мөлжлөгийн нэг хэлбэр мөн гэдэгтэй санал нийлж байна гэсэн бол бүлгийн ярилцлаганд оролцогчид биеэ үнэлэлт, бэлгийн мөлжлөгийг хоёр өөр ойлголт гэж үзээд бэлгийн мөлжлөг биеэ үнэлэлтийг бодвол харьцангуй бага үйлдэгддэг гэжээ. Судалгаанд хамрагдсан хоёр хүний нэг нь тухайн орон нутагтаа бэлгийн мөлжлөг үйлдэгддэг эсэхийг мэдэхгүй гэж хариулсан байна. Хүний наймаачид ихэвчлэн эмзэг бүлгийн охид, эмэгтэйчүүдийг худалдахаас гадна сул дорой хэн нэгнийг өөрсдийн орлогын эх үүсвэрээ болгон ашигладаг асуудал манай оронд ч бас их байдаг болох нь судалгаанд хамрагдагчдын хариултаас харагдаж байна. Тэд энэ гэмт хэрэгт дараах бүлгийн хүмүүс илүү их өртөж, хохирогч болж байна гэж үзсэн. Үүнд:

- Бага насандаа хүчирхийлэлд өртөж байсан;
- Хараа хяналт багатай гэр бүлийн орчинд өссөн;
- Сургууль завсардсан буюу боловсрол багатай;
- Гэр бүлийн амьдралын нөхцөл муу;
- Хагас болон бүтэн өнчин;
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй орчинд өссөн хүүхдүүд

Өөрөөр хэлбэл эмзэг бүлгийн охид, эмэгтэйчүүд энэ гэмт хэрэгт их өртөж байна. Мөн эрэгтэй хүүхэд ч гэсэн биеэ үнэлж байна гэсэн аман яриа их гарч байна гэсэн. Иймд бэлгийн хүчирхийллийн хэргийг таслан зогсоох, шийтгэх, хохирогчдыг нэн даруй нөхөн сэргээхэд холбогдох эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хохирогчдод үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хэрэгтэй байна.

Биеэ үнэлэлт болон бэлгийн мөлжлөгт өртсөн хохирогчдод туслалцаа үзүүлэх талаар энэ чиглэлээр ажилладаг цагдаа, шүүгч, өмгөөлөгч, нийгмийн ажилтан, гэр бүл, хүүхдийн асуудлаар ажилладаг албан тушаалтнууд нь тодорхой хэмжээний мэдлэг, ойлголттой гэсэн бол олон нийтийн төлөөлөл өөрсдийгөө хангалттай мэдлэг, мэдээлэлгүй гэжээ. Тэд энэ төрлийн гэмт хэргийн хохирогчдод үйлчилгээ үзүүлдэг байгууллага ховор байна. Тийм учраас энэ төрлийн гэмт хэрэгт өртсөн хохирогчид тэр бүр хандаад байдаггүй. Дийлэнх нь цагдаад ханддаг байх гэсэн байна.

Судалгаанд хамрагдагчид энэ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд зориулсан мэдээлэл, нэвтрүүлэг, хэвлэл мэдээллийн хэрэгслээр хангалттай гардаггүй гэсэн бол энэ чиглэлээр ажилладаг мэргэжилтнүүд сургалт, үйл

ажиллагаанд хамрагдах замаар мэдээлэл ойлголт авдаг гэжээ. Цаашид төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан бодит мэдээлэл өгөх үйл ажиллагааг тогтвортой явуулах хэрэгтэй. Гэхдээ мэдээллийн агуулга олон нийтэд айдас төрүүлэхээсээ илүү мэдлэг олгоход чиглэсэн байвал илүү үр дүнтэй байх болно гэж санал бодлоо илэрхийллээ.

Судалгаанд хамрагдагчдын 83.7 хувь нь энэ гэмт хэрэгтэй тэмцэх боломжтой гэж үзэж байгаа бол бүлгийн болон ганцаарчилсан ярилцлаганд оролцогчид өөрсдийгөө энэ төрлийн гэмт хэргийн хохирогчдод дараах төрлийн анхан шатны туслалцаа, үйлчилгээг үзүүлэх боломжтой гэсэн байна. Үүнд:

- Холбон зуучлах;
- Сэтгэл зүйн зөвлөгөө;
- Хууль зүйн зөвлөгөө;
- Сургалт;
- Сурталчилгааны ажил зохион байгуулах

Судалгаанд хамрагдсан таван хүний дөрөв нь энэ хэргийг таслан зогсоох ёстой гэж үзсэн бөгөөд үүний тулд дараах үйл ажиллагааг явуулахыг санал болгож байна. Үүнд:

- Хууль, дүрэм, журмаа чангатгах;
- Олон нийтийн сүлжээгээр мэдээлэл явуулах;
- Холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах;
- Ажлын байр нэмэгдүүлэх;
- Биеэ үнэлэгч, худалдан авагч нарт хариуцлага тооцох;
- Биеэ үнэлэгчдийг орогнуулдаг үйлчилгээний газруудыг илрүүлж хаах, болзошгүй газруудад байнга хяналт шалгалт хийж байх;
- Хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх
- Биеэ үнэлэгчдийг нийгэмшүүлэх зэрэг үйл ажиллагааг дурьджээ.

Төрөөс хохирогчдод зориулсан нийгмийн ажлын цогц үйлчилгээг сайжруулах, энэ чиглэлээр ажиллаж буй байгууллагуудад санхүүжилт төсвөөс хуваарилан олгох, хохирогч, гэрч хамгааллын тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай байна.

Энэ хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулбал илүү үр дүнтэй гэж үзэж байна. Үүнд:

- Олон нийтэд болон хохирогчдод мэдээлэл, зөвлөгөө өгдөг цэгүүдийг эрсдэл өндөртэй орон нутагт байгуулах;
- Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллагууд энэ асуудлаар хамтран ажиллах;
- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтвортой мэдээлэл, ойлголт өгөхөд

- чиглэсэн ярилцлага, нэвтрүүлэг, шторк цацах;
- ЕБС, их, дээд сургууль, МСҮТ-д суралцагчдад тогтмол мэдээлэл өгөх үйл ажиллагаа зохион байгуулах;
- Энэ чиглэлээр ажилладаг мэргэжилтнүүдийг тогтвор суурьшилтай ажиллуулж, чадавхижуулах;
- Алслагдсан сум, баг, гэр хорооллын иргэдийн дунд хүрч очин явууллын мэдээлэл өгөх үйлчилгээг нэвтрүүлэх, энэ чиглэлээр ажиллах ажилтнуудыг бэлтгэх, чадавхижуулах;
- Олон нийтэд сургалт, сурталчилгаа байнга зохион байгуулж мэдлэг боловсрол олгож байх;
- Биеэ үнэлэгчид болон худалдан авагчдад хуулийн хариуцлага тооцох гэх мэтээр урьдчилан сэргийлэх болон хамгаалах үйл ажиллагааг өргөн хүрээнд явуулах хэрэгтэй байна.

Энэ гэмт хэрэгт өртөх эрсдэлтэй хүмүүст туслахын тулд дараах төрлийн үйл ажиллагаа, арга хэмжээ авч хэрэгжүүлэх саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- Урьдчилан сэргийлэх чиглэлээр эрсдэлт бүлгийнхэнд чиглэсэн сургалт хийх;
- Хилээр гарахаас өмнө эрсдэлт бүлгийг мэдээллээр хангах, ярилцлага хийх;
- Тодорхой цэгүүдэд компанит ажлыг тогтмол зохион байгуулах;
- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр энэ гэмт хэргийн талаар ойлголт, мэдээлэл өгөхөд чиглэсэн ярилцлага, нэвтрүүлэг, шторк цацах;
- Эрэгтэйчүүдэд мэдээлэл өгөх, ялангуяа хилийн бүс орчимд байгаа хүн болон бараа тээвэрлэж буй жолооч нарт чиглэсэн үйл ажиллагаа;
- Үйлчилгээ авахаар ирж буй хохирогчтой ажиллах ажилтнуудыг чадавхижуулах;
- Хамгийн гол нь тухайн орон нутагт хийгдэж буй урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа тогтвортой байх хэрэгтэй гэсэн байна.

Биеэ үнэлэлт болон бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэхийн тулд улсын хэмжээнд олон нийтийг энэ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, энэ гэмт хэргийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх цогц, системтэй бодлого, хөтөлбөртэй байх хэрэгтэй байна.

Эцэст нь хэлэхэд судалгаанд хамрагдсан хүмүүсийн 17.5-35.5 хувь нь биеэ үнэлэлтийн, 17.7-53.8 хувь нь бэлгийн мөлжлөгийн, 14.8-37.3 хувь нь биеэ үнэлэгчдийг худалдан авагч нарт хуулийн хариуцлага хүлээлгэх эсэх талаарх асуултын хариултуудад “мэдэхгүй” гэж хариулсан нь тухайн асуудлаар ямар нэг мэдлэг ойлголт аваагүй байгаатай холбоотой гэж үзэж байна. Иймд энэ талаар олон нийтэд ойлголт, мэдлэг олгох бүх төрлийн арга хэмжээг зохион байгуулан явуулах шаардлагатай гэж үзэж байна.

БҮЛЭГ 7

Үр дүнгийн хүснэгтүүд

Хүснэгт 1 Судалгаанд хамрагдсан хүний тоо, насны бүлэг, суурьшил, боловсролын түвшин, ажил эрхлэлтийн байдал, хүйсээр

	Тоогоор			Хувиар			
	Бүгд	Үүнээс		Бүгд	Үүнээс		
		Эрэгтэй	Эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй	
Бүгд	710	355	355	100.0	50.0	50.0	
Насны бүлгээр	16-19	20	13	7	100.0	65.0	35.0
	20-24	79	40	39	100.0	50.6	49.4
	25-29	145	77	68	100.0	53.1	46.9
	30-34	149	71	78	100.0	47.7	52.3
	35-39	125	60	65	100.0	48.0	52.0
	40-44	90	45	45	100.0	50.0	50.0
	45-49	42	19	23	100.0	45.2	54.8
	50-54	25	11	14	100.0	44.0	56.0
	55-59	23	13	10	100.0	56.5	43.5
	60 ба дээш	12	6	6	100.0	50.0	50.0
Суурьшлаар	Дархан-Уул	70	34	36	100.0	48.6	51.4
	Орхон	70	35	35	100.0	50.0	50.0
	Замын - Үүд	55	27	28	100.0	49.1	50.9
	Дорнод	70	35	35	100.0	50.0	50.0
	Өмнөговь	70	35	35	100.0	50.0	50.0
	Улаанбаатар	375	189	186	100.0	50.4	49.6
Боловсролын түвшнээр	Дээд	484	238	246	100.0	49.2	50.8
	Тусгай мэргэжлийн дунд	57	31	26	100.0	54.4	45.6
	Техникийн болон мэргэжлийн	47	18	29	100.0	38.3	61.7
	Бүрэн дунд	88	48	40	100.0	54.5	45.5
	Суурь	16	10	6	100.0	62.5	37.5
	Бага	14	9	5	100.0	64.3	35.7
	Боловсролгүй	4	1	3	100.0	25.0	75.0
Ажил эрхлэлтийн байдлаар	Суралцдаг	25	15	10	100.0	60.0	40.0
	Төрийн албан хаагч	437	223	214	100.0	51.0	49.0
	ТББ-ын ажилтан	67	30	37	100.0	44.8	55.2
	Хувиараа хөдөлмөр эрхэлдэг	71	37	34	100.0	52.1	47.9
	Хувийн компанид ажилладаг	64	29	35	100.0	45.3	54.7
	Малчин	1	1		100.0	100.0	0.0
	Ажилгүй	32	14	18	100.0	43.8	56.3
	Бусад	13	6	7	100.0	46.2	53.8

Хүснэгт 2

Биеэ үнэлэлтийн талаарх судалгаанд хамрагдагчдын үзэл бодол, хүний тоогоор

	Санал огт нийлэхгүй байна	Санал нийлэхгүй байна	Мэдэхгүй	Санал нийлж байна	Маш их санал нийлж байна	ДҮН
Таны бодлоор танай орон нутагт биеэ үнэлэлт байдаг уу?	24	21	286	306	73	710
Монголд биеэ үнэлэлт хууль ёсны болгох хэрэгтэй юу?	189	188	124	179	30	710
Насанд хүрэгчдэд бэлгийн харилцааг мөнгөөр худалдаж авах зөвшөөрөл олгох нь зөв үү?	269	219	136	81	5	710
Биеэ үнэлэлтийг хуулиар зөвшөөрвөл эрэлт нэмэгдэнэ	175	143	205	166	21	710
Биеэ үнэлэлт аль ч нийгэмд байх л ёстой асуудал	174	206	184	141	5	710
Биеэ үнэлэлтийг хуулиар зөвшөөрснөөр эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгт ашиглах явдлаас сэргийлж чадна	121	186	202	187	14	710
Биеэ үнэлэлт саун, массаж, шөнийн цэнгээний газрууд гэлтгүй хаа сайгүй явагдаж байна	20	26	151	411	102	710
Биеэ үнэлэлтийг хүлээн зөвшөөрвөл худалдан авагчдын тоо нэмэгдэнэ	77	119	252	227	35	710

Хүснэгт 3

Биеэ үнэлэлтийн талаарх судалгаанд хамрагдагчдын үзэл бодол, дүнд эзлэх хувиар

	Санал огт нийлэхгүй байна	Санал нийлэхгүй байна	Мэдэхгүй	Санал нийлж байна	Маш их санал нийлж байна	ДҮН
Таны бодлоор танай орон нутагт биеэ үнэлэлт байдаг уу?	12	28	382	267	21	710
Монголд биеэ үнэлэлт хууль ёсны болгох хэрэгтэй юу?	13	101	198	352	46	710
Насанд хүрэгчдэд бэлгийн харилцааг мөнгөөр худалдаж авах зөвшөөрөл олгох нь зөв үү?	5	50	125	431	99	710
Биеэ үнэлэлтийг хуулиар зөвшөөрвөл эрэлт нэмэгдэнэ	11	71	302	282	44	710
Биеэ үнэлэлт аль ч нийгэмд байх л ёстой асуудал	6	25	139	444	96	710
Биеэ үнэлэлтийг хуулиар зөвшөөрснөөр эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгт ашиглах явдлаас сэргийлж чадна	10	81	198	361	60	710
Биеэ үнэлэлт саун, массаж, шөнийн цэнгээний газрууд гэлтгүй хаа сайгүй явагдаж байна	20	26	151	411	102	710
Биеэ үнэлэлтийг хүлээн зөвшөөрвөл худалдан авагчдын тоо нэмэгдэнэ	77	119	252	227	35	710

Хүснэгт 4

Бэлгийн мөлжлөгийн талаарх судалгаанд хамрагдагчдын үзэл бодол, хүний тоогоор

	Санал огт нийлэхгүй байна	Санал нийлэхгүй байна	Мэдэхгүй	Санал нийлж байна	Маш их санал нийлж байна	ДҮН
Таны бодлоор танай орон нутагт бэлгийн мөлжлөг үйлдэгддэг үү?	12	28	382	267	21	710
Биеэ үнэлэлт бол бэлгийн мөлжлөгийн нэг хэлбэр юм	13	101	198	352	46	710
Хүний наймаачид ихэвчлэн эмзэг бүлгийн охид, эмэгтэйчүүдийг худалддаг	5	50	125	431	99	710
Биеэ үнэлж буй охид, эмэгтэйчүүдийн дийлэнх нь өмнө нь бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэргийн хохирогч болсон байдаг	11	71	302	282	44	710
Хүний наймаачид нь сул дорой, эмзэг хэн нэгнийг өөрсдийн орлого олох эх үүсвэрээ болгон ашигладаг	6	25	139	444	96	710
Биеэ үнэлж буй охид, эмэгтэйчүүдийн дийлэнх нь энэ байдлаасаа "зугтах"-ыг хүсдэг ч хэнээс, хаанаас тусламж авахаа мэддэггүй	10	81	198	361	60	710

Хүснэгт 5

Бэлгийн мөлжлөгийн талаарх судалгаанд хамрагдагчдын үзэл бодол, дүнд эзлэх хувиар

	Санал огт нийлэхгүй байна	Санал нийлэхгүй байна	Мэдэхгүй	Санал нийлж байна	Маш их санал нийлж байна	ДҮН
Таны бодлоор танай орон нутагт бэлгийн мөлжлөг үйлдэгддэг үү?	1.7	3.9	53.8	37.6	3.0	100.0
Биеэ үнэлэлт бол бэлгийн мөлжлөгийн нэг хэлбэр юм	1.8	14.2	27.9	49.6	6.5	100.0
Хүний наймаачид ихэвчлэн эмзэг бүлгийн охид, эмэгтэйчүүдийг худалддаг	0.7	7.0	17.6	60.7	13.9	100.0
Биеэ үнэлж буй охид, эмэгтэйчүүдийн дийлэнх нь өмнө нь бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэргийн хохирогч болсон байдаг	1.5	10.0	42.5	39.7	6.2	100.0
Хүний наймаачид нь сул дорой, эмзэг хэн нэгнийг өөрсдийн орлого олох эх үүсвэрээ болгон ашигладаг	0.8	3.5	19.6	62.5	13.5	100.0
Биеэ үнэлж буй охид, эмэгтэйчүүдийн дийлэнх нь энэ байдлаасаа "зугтах"-ыг хүсдэг ч хэнээс, хаанаас тусламж авахаа мэддэггүй	1.4	11.4	27.9	50.8	8.5	100.0

Хүснэгт 6

Биеэ үнэлэгчдийг худалдан авагч нарт хуулийн хариуцлага хүлээлгэх эсэх талаарх судалгаанд хамрагдагчдын үзэл бодол, хүний тоогоор

	Санал огт нийлэхгүй байна	Санал нийлэхгүй байна	Мэдэхгүй	Санал нийлж байна	Маш их санал нийлж байна	ДҮН
Биеэ үнэлэгчдийг худалдан авагч нарт хуулийн хариуцлага хүлээлгэх ёстой гэж үздэг үү?	10	82	116	361	141	710
Биеэ үнэлэлтийн талаарх өнөөгийн хууль тогтоомжид заасан хариуцлагууд оновчтой гэж та бодож байна уу?	46	219	345	96	4	710
Биеэ үнэлэгчдийг худалдаж авсны улмаас хуулийн хариуцлага хүлээж буй этгээдийн нэрийг олон нийтэд зарлах хэрэгтэй	39	212	173	223	63	710
Биеэ үнэлэгчийг худалдан авч буй хүнийг гэмт хэрэгтэн гэж бүртгэж авах ёстой	34	176	168	271	61	710
Охид, эмэгтэйчүүдтэй бэлгийн харилцаанд орохын тулд худалдаж авсан хүмүүст ял шийтгэл оноох ёстой	24	139	182	291	74	710
Охид, эмэгтэйчүүдтэй бэлгийн харилцаанд орохын тулд худалдаж авсан хүмүүс торгууль төлөх ёстой	18	87	152	355	98	710
Охид, эмэгтэйчүүдтэй бэлгийн харилцаанд орохын тулд худалдаж авсан хүмүүст хорих ял оноох хэрэгтэй	35	180	206	222	67	710

Хүснэгт 7

Биеэ үнэлэгчдийг худалдан авагч нарт хуулийн хариуцлага хүлээлгэх эсэх талаарх судалгаанд хамрагдагчдын үзэл бодол, дүнд эзлэх хувиар

	Санал огт нийлэхгүй байна	Санал нийлэхгүй байна	Мэдэхгүй	Санал нийлж байна	Маш их санал нийлж байна	ДҮН
Биеэ үнэлэгчдийг худалдан авагч нарт хуулийн хариуцлага хүлээлгэх ёстой гэж үздэг үү?	1.4	11.5	16.3	50.8	19.9	100.0
Биеэ үнэлэлтийн талаарх өнөөгийн хууль тогтоомжид заасан хариуцлагууд оновчтой гэж та бодож байна уу?	6.5	30.8	48.6	13.5	0.6	100.0
Биеэ үнэлэгчдийг худалдаж авсны улмаас хуулийн хариуцлага хүлээж буй этгээдийн нэрийг олон нийтэд зарлах хэрэгтэй	5.5	29.9	24.4	31.4	8.9	100.0
Биеэ үнэлэгчийг худалдан авч буй хүнийг гэмт хэрэгтэн гэж бүртгэж авах ёстой	4.8	24.8	23.7	38.2	8.6	100.0
Охид, эмэгтэйчүүдтэй бэлгийн харилцаанд орохын тулд худалдаж авсан хүмүүст ял шийтгэл оноох ёстой	3.4	19.6	25.6	41.0	10.4	100.0
Охид, эмэгтэйчүүдтэй бэлгийн харилцаанд орохын тулд худалдаж авсан хүмүүс торгууль төлөх ёстой	2.5	12.3	21.4	50.0	13.8	100.0
Охид, эмэгтэйчүүдтэй бэлгийн харилцаанд орохын тулд худалдаж авсан хүмүүст хорих ял оноох хэрэгтэй	4.9	25.4	29.0	31.3	9.4	100.0


Хүснэгт 8


Монголд биеэ үнэлэлт хэр их байдаг талаарх судалгаанд хамрагдагчдын үзэл бодол

	Маш бага	Бага	Мэдэхгүй	Их	Маш их	ДҮН
а)Тоогоор						
Бүгд	8	44	175	351	132	710
Үүнээс:						
Эрэгтэй	5	19	90	175	66	355
Эмэгтэй	3	25	85	176	66	355
Суурьшлаар:						
Дархан-Уул	1	4	21	33	11	70
Орхон	1	6	16	35	12	70
Замын - Үүд	1	4	15	27	8	55
Дорнод	1	1	26	34	8	70
Өмнөговь	1	2	21	32	14	70
Улаанбаатар	3	27	76	190	79	375
б) Хувиар						
Бүгд	1.2	6.2	24.6	49.4	18.6	100.0
Үүнээс:						
Эрэгтэй	1.5	5.3	25.3	49.2	18.6	100.0
Эмэгтэй	0.8	7.0	23.9	49.6	18.6	100.0
Суурьшлаар:						
Дархан-Уул	1.4	5.7	30.0	47.1	15.7	100.0
Орхон	1.4	8.6	22.9	50.0	17.1	100.0
Замын - Үүд	1.8	7.3	27.3	49.1	14.5	100.0
Дорнод	1.4	1.4	37.1	48.6	11.4	100.0
Өмнөговь	1.4	2.9	30.0	45.7	20.0	100.0
Улаанбаатар	0.8	7.2	20.3	50.7	21.1	100.0

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ

 Монгол Улс
Улаанбаатар хот-211238
Шуудангийн хайрцаг-321

 Утас/Факс (+976) 11-311512
Итгэлийн утас: 1800-1903, 7011-1112

 MongolianGenderEqualityCenter

 gendereqcen@magicnet.mn

 www.stoptrafficking.mn